

Социализмын/аар бүтээсэн үндэсний баатар-Чингис хаан
БНМАУ дахь Чингис хааны тухай дискурс ба Монголын үндсэрхэг үзэл
бүрэлдэх үйл явц талаарх нэгэн гипотез (1941-1966 он)¹

Шимамүра Иппэй
(National Museum of Ethnology)

Эхлэл

- I. ЗХУ-ын удирдлага дор үндэсний түүх бичгээ эмхэтгэх явцад монголын сэхээтнүүдийн хэрэгжүүлсэн тактик (1954-1966 он)
- II. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэсэн явдал болон (1962 он), түүний сөрөг үр дагавар (1962 оноос хойш)

Төгсгөл

Эхлэл

1989 оны 12 дугаар сард эхэлсэн Монголын ардчилсан хөдөлгөөнийг тухайн үеийн монголчууд ЗХУ-ын хүлээснээс ангижрах нэг төрлийн “үндэстний сэргэлтийн хөдөлгөөн” хэмээн ойлгож байв. Ялангуяа ЗХУ-ын үед нэрийг нь ч дуудахаас ч эмээдэг байсан Чингис хаан энэ хөдөлгөөний чухал бэлгэ тэмдэг болсныг хэн ч мэдэх буй за. Жишээлбэл тухайн үед “Хонх” хамтлаг Чингис хааны тухай

*“Дуурсах алдрыг тань дуулах нь бүү хэл
Дуудах нэрийг тань хэлэхээс эмээж явсан
Хөх Монголын үр сад хөөрхий биднийгээ өршөө”*

хэмээн дуулж, ард олны халуун дэмжлэгийг олжээ. Энэ дуу тэр үеийн Монголын ард иргэдийн сэтгэлийн илрэл байсан нь дамжиггүй.

Үндсэрхэг үзлийн шинжтэй иймэрхүү хөдөлгөөн ардчиллаас хойш ч зогсоогүй. Ялангуяа Чингис Их Монгол улсын хаанд өргөмжлөгдсөний 800 жилийн ой тохиох 2006 онд 70 гаруй тэмдэглэлт арга хэмжээг төр засгийн байгууллагуудаас хийхээр төлөвлөсөн² ба энэ үеэр улам бүр хүчээ авчээ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын засгийн газрын ордны өмнө талд болон Төв аймгийн Эрдэнэ суманд аварга том Чингисийн хөшөө сүндэрлэлээ. Мөн нисэх онгоцны буудлын нэрийг “Чингис хаан” болгож өөрчлөв.

¹ Орчуулсан Д.Уламцэнгэл (Шига мужийн их сургуулийн докторант)

² *Чингис хааныг соёлын нөөц болгон ашигласан нь - Монгол, Япон, Орос, Хятад улсын харьцуулалтаас.* “Хүмүүн соёл” сэтгүүл, Шига мужийн их сургуулийн Хүмүүн соёлын факультетийн судалгааны тайлан, дугаар 24, 2008 он, тал 7-34.
(Bunka shigen toshite riyosareru Chingisu hân-mongoru, nihon, roshia, chyugoku no hikaku kara, Ningen buka Shiga kenritsu daigaku ningen bunka gakubu kenkyu hókoku 24-go, (2008), p. 7-34.)

Ардчилал эхлэхтэй зэрэгцээд эрдэм шинжилгээний салбарт ч Чингисийн үйл хэрэгт дахин үнэлэлт дүгнэлт өгч, дэлгүүрүүдэд түүнтэй холбоотой тоо томшгүй олон ном зарагдаж эхлэв. Тэр дотор Чингис хааны удирдан зохион байгуулах чадварын тухай, сайн дипломатч хэмээн магтан сайшаасан бүтээлээс эхлээд соёлын баатарт тооцох хандлага ч гарч эхэлжээ.

Монголд 1990-ээд оны эхээр социализм нурж, ардчилал эхлэхэд Чингис хааныг үндсэрхэг үзлийн баялаг болгон ашиглаж эхэлсэн гэж үздэг. Түүнчлэн социализмын жилүүдэд (1924-1992 он) ЗХУ-ын Коммунист намыг аялдан дагалдагч МАХН-аас үндэсний баатрын нэрийг хэлэхийг хүртэл хориглож, мартагдсан гэж тайлбарласаар иржээ. Үнэндээ Монголын сэхээтнүүд ч Чингисийн нэрийг хэлэх цээртэй байсан,³ түүний талаар бичих зохиох ч хориотой байлаа⁴ зэргээр ярьж байв.

Энэ талаар Америкийн монгол судлаач Алисиа Кампи, монголчууд ардчиллаас хойш Чингисийн талаарх үзлээ өөрчилж чадсан⁵ нь даяаршил болон Америк зэрэг барууны орнуудын ачаар болсон хэрэг гэж үзжээ.

Гэвч Чингис хааныг магтан ярьж дурсах зэрэг монголчуудын үндсэрхэг үзэл нь ЗХУ-ын хүлээснээс ангижирснаар хүчээ авсан гэж хялбарханаар тайлбарлачихаж үл болох юм. Хэрэв социализмын үед нэр нь хүртэл мартагдсан байсан гэж үзвэл, ардчилалтай зэрэгцээд гэнэтхэн л үндсэрхэг үзлийн бэлгэ тэмдэг болж гарч ирэхгүй байсан нь лавтай. Харин аль дээр социализмын үед Чингис хаан хэдийнээ (нууцаар ч гэлээ) үндсэрхэг үзлийн бэлгэ тэмдэг болчихсон байсан гэж үзэх нь зүйд нийцнэ.

Бенедикт Андерсон, орчин үежлийн явцад ном, сонин сэтгүүл, хэвлэлийн арга технологи сайжирсаар, алслагдмал нутагт амьдарч буй үл таних хүмүүс бие биенээ нэг гаралтай үндэстэн хэмээн төсөөлж эхэлснээр үндсэрхэг үзэл бий болдог хэмээн үзжээ. Андерсон үүнийг “хэвлэлийн капитализм” (printing capitalism) гэж нэрлэсэн.⁶

³ XX зууны сүүдрийг гэрэлтүүлсэн зохиолч Монгол улсын ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн яриа Конагая Юки (ред) “XX зууны монголчууд – Социализмын үеийн хүмүүсийн яриа” Японы угсаатны зүйн төв музейн тайлан-41, 2003 он, тал 210.

(20 seiki no kage ni hikari wo ateru bungakusha – Mongoru koku no jinmin sakka Dendebiin Purebudoruji ha kataru, Konagaya Yuki hen, *Mongoru ni okeru 20 seiki- Shakaishugi wo ikita hitobito no shyogen* -, Kokuritsu Minzoku hakubutsukan chyosa hookoku 41 (2003), p.210.)

⁴ Ш.Нацагдорж, *Чингис хааны цадиг*. Улаанбаатар, 1991 он, тал 5.

⁵ Alicia J.Campi, Globalization’s Impact on Mongolian Identity Issues and the Image of Chinggis Khan in Henry G.Schwarz (ed.), *Mongolian Culture and Society in the Age Globalization*. Studies on East Asia, Vol.26, pp.67-99. Гэвч Кампигийн тайлбараас эсрэгээр, Америкийн цуврал кино, уран сайхны кинонд Монгол болон Чингис хааныг сөргөөр дүрсэлсээр ирсэн билээ. Зохиогчийн “*Чингис хааныг соёлын нөөц болгон ашигласан нь*” номын эхний хэсгээс дэлгэрэнгүй харна уу.

⁶ Бенедикт Андерсон, Ширазиши Такаши, Ширазиши Саяака (орч), *Төсөөллийн хүй нийгэм-үндсэрхэг үзлийн үүсэл ба дэлгэрэлт*, Шёсэки кообоо хаяама: 2007 (1983) он. (Benedict Anderson (Shiraishi Takashi, Shiraishi Sayaka (yaku), Teihon Soozoo no kyodoot-ai-nashonarizumu no kigen to ryukoo-Shoseki kooboo hayama, 2007 (1983)).

Харин Монгол социализмын үед (1924-1992 он) иргэншиж, орчин үежиж тэр байтугай хэвлэлийн технологи өргөн дэлгэрснээрээ ихээхэн онцлогтой. 1945 онд ЗХУ-ын нөлөөн дор уламжлалт уйгуржин монгол бичгээ кирилл үсгээр сольж, орчин үеийн боловсролын тогтолцоо тавигдаж, бичиг үсэгтэй хүмүүсийн тоо нэмэгдсэн⁷ нь ч энэ үед болсон хэрэг. Тийм учраас Чингисийн нэр, намтар түүхийн талаар энгийн иргэд мэдсэн үе нь үнэндээ социализмын үе, нэн ялангуяа кирилл үсгээр боловсрол олгож эхэлсэн 1940-өөд оны сүүлийн хагас гэж үзэхэд буруудахгүй болов уу. Гэвч тэр үеийн бүхий л ном сонинд үндсэндээ ЗХУ-ын коммунист нам, түүнийг аялдан дагагч МАХН-ын үзэл санаа туссан гэхэд хилсдэхгүй.

Тэгсэн хэдий боловч монголын сэхээтнүүд ЗХУ-аар дамжуулан Чингисийн талаар мэдэхийн зэрэгцээ тухайн мэдээллээ шууд утгаар нь бус, эсрэгээр нь ойлгосноор үндсэрхэг үзлийг бий болгосон гэлтэй. Энэхүү ЗХУ-ын социализмын нөлөөн дор бүрэлдсэн дээрх үндсэрхэг үзлийг “хэвлэлийн социализм” (printing socialism) хэмээн нэрлэе. Энэ өгүүлэлд социализмын үеийн Монголд Чингис хааныг хэрхэн дүрсэлж байсныг, түүнийг дүрсэлсэн гол бүтээл “БНМАУ-ын түүх”-ийн агуулга, түүнийг хэрхэн эмхэтгэсэн тухай үйл явцыг судалснаар “хэвлэлийн социализм”-аар үндсэрхэг үзэл хэрхэн бий болсон талаар авч үзэцгээе.⁸

Харин антропологич Кристофер Каплонский нь Монгол улсад социализмын жилүүдэд түүхийн судалгааны номууд болон сурах бичгүүдэд Чингис хааны тухай үргэлж бичигдсээр ирсэн боловч монголчууд ардчиллаас хойш Чингис хааныг тэр үед “мартагдсан байсан, “түүний тухай ярихыг хүртэл хориглож байсан” хэмээн ярьдаг болсон зөрчлийг онцолсон юм. Улмаар дээрх зөрчилтэй хоёр дискурсийг “бичигдсэн түүх (documented past)”, “эргэн дурсагдсан түүх (recalled past)” гэж нэрлэн, хоёр зөрчилтэй өнгөрсөн цагийн (past) ойлголт хэрхэн бий болсон учрыг тайлах гэж хичээсэн юм.⁹ Каплонский энэхүү зөрчлийн учрыг монголчууд ардчиллын дараа үндэсний ижилслээ (national identity) бүтээхийн тулд социализмын үеийг буруутгах хэрэгтэй байсан гэж үзжээ. Өөрөөр хэлбэл ардчилалын ачаар Чингисийн тухай эергээр бичиж илэрхийлдэг болсон гэдгээ зөвтгөхийн төлөө социализмын үед үүний эсрэгээр Чингисийг үгүйсгэгдэж байсан гэх мэтийн дурсамжийг зохиох хэрэгтэй байсан гэжээ. Улмаар Каплонский Чингисийн илэрхийлэлт (representation) талаар

⁷ Монголчуудын бичиг үсэгт тайлагдсан хүмүүсийн тоо 1926 онд 10.000 (нийт хүн ам 684.000) байснаас 1940 онд 127.000 (нийт хүн ам 739.000) болж өсчээ. Гэтэл кирилл үсэг хэрэглэж эхэлснээс хойш 7 дээш настай бичиг үсэгтэй хүн 42.3%, 1956 онд 72%, 1963 онд 90%-аас дээш огцом өссөн байна. Доорх материалаас дэлгэрэнгүй харна уу. Монголын ШУА (ред), *Монголын түүх* 2, 1988 он, тал 218-220.

⁸ Зохиогч уг судалгаагаа доорх номонд тулгуурлан бичсэн. *Чингис хаан хэний баатар вэ? Монгол, Япон, Хятад, Евро-Америк, Оросын харьцуулалтаас*. Улаанбаатар: Эдмон, 2012.

⁹ Christopher Kaplonski “The Case of the Disappearing Chinggis Khaan: Dismembering the Remembering”, *Ab Imperio* 4 (2005), pp.147-173.

“төсөөллийн (imagined) дарамт”, “мартагдсан” гэх мэтийн дискурсийг “домгийн чанартай түүх (mythico-history)” хэмээн нэрлэсэн аж.

Гэвч Каплонский социализмын үед Чингисийг тэмдэглэж байсан эсэхийг хэт анхаарч, дотоод агуулгыг нь хангалттай судлаагүй юм. Ялангуяа социализмын үеийн албан ёсны Монголын түүх болох “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх” (3 удаа эмхэтгэгдсэн)-ийн талаар ерөөс судлаагүй шинжтэй. Тийм учраас эл өгүүлэлдээ миний бие Каплонскийн нэрлэж буй “домгийн чанартай түүх”-ийг үнэхээр домог байсан эсэхийг шалгахын төлөө, түүний судлалгүй орхисон “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх”-ийн¹⁰ доторх агуулгыг судлахаас гадна эл номыг эмхэтгэх үйл явц, ялангуяа Монгол, Зөвлөлт хоёр орны эрдэмтэд хамтарч албан ёсны Монгол улсын түүхийг бичихийн тулд хийсэн хэлэлцүүлэгт анхаарлаа хандуулан түүний бодит байдлыг тодруулахыг зорьсон болно.

Английн түүхч Орландо Файжес, ерөнхийдөө ихэнх оросууд ЗХУ байгуулагдахаас өмнө нь ч, дараа нь ч ялгаагүй, XIX зуунд зохиогдсон “арьс өнгө” (race) хэмээх ухагдахуун бий болсны нөлөөгөөр хоцрогдмол, бүдүүлэг, царай муутай, тэнэг мулгуу зэрэг хэв шинжийг монголиод (шар арьстан) эсвэл монгол шинжид (mongolness) хамаатуулах европчуудын сэтгэхүйг нэвтрүүлснээр, өөрийгөө европчуудаас дутуу хэмээх комплекс (inferior complex) бий болгож эхэлсэн гэж үздэг.¹¹ Өөрөөр хэлбэл, Оросын сэхээтнүүдийн дунд “евроазийц” (20-р зууны эхээр Оросыг Европ биш харин Евроазийн соёл иргэншлийн орон гэж үздэг байсан хүмүүс) үзэлтэй хүмүүсийг эс тооцвол, Чингис хааныг шууд, хүн биш, зэрлэг бүдүүлэг, харгис хэрцгий, үзэшгүй муухайтай холбон үзсээр ирсэн гэж хэлж болно. Нэг үгээр хэлбэл, адилхан социалист улс хэрнээ ЗХУ ба Монголын сэхээтнүүдийн хооронд Чингис хааны талаарх ойлголт зөрүүтэй байсан нь гайхмаар хэрэг биш юм. Тийм ч учраас “БНМАУ-ын түүх”-ийг эмхэтгэх явцад ЗХУ-Монголын хооронд болсон хэлэлцээрийн үйл явцыг дахин нягтлах шаардлага тулгарч байгаа юм.

Социализмын үед “БНМАУ-ын түүх” ном нь 1954 онд орос хэлээр анх хэвлэгдэж¹² (монгол хэлээр 1955 онд орчуулагдан хэвлэгдсэн),¹³ хоёр дахь

¹⁰ Чингисийн талаарх судалгааг социализмын үед ч үргэлжлүүлэн хийсээр ирсний нотолгоо нь “Монголын түүх”-ийн сайжруулсан хэвлэлд 3-хан мөр тэмдэглэл байсан хэдий ч түүний агуулгыг сайтар судлаагүй юм. Мөн тэнд., тал 160-161.

¹¹ Orlando Figes, *Natasha's Dance: A Cultural History of Russia*, London: Penguin Books, 2003 (2002), pp.358-429.

¹² Б.Д.Греков, С. А.Козин, А.А. Губер, Е.М.Зуков, С.В.Кисерёв (ред.), *История Монгольской Народной Республики*, Москва, Академи Наук СССР, 1954.

¹³ Б.Д.Греков, С. А.Козин, Б.Ширэндэв, Ц. Дамдинсүрэн ба бусад (ред.), *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх*, Улаанбаатар: Улсын хэвлэл, 1955.

хэвлэл (1966 он),¹⁴ гурав дахь хэвлэл (1984 он)¹⁵ буюу гурван удаа эмхэтгэгдэн хэвлэгджээ. Хоёр дахь хэвлэл, гурав дахь хэвлэл нь орос, монгол хэлээр нэгэн зэрэг хэвлэгдсэн байна. “БНМАУ-ын түүхийн анхдугаар хэвлэлд, Чингисийг нүүдэлчин иргэдийг мөлжигч, харийн улсуудын хувьд цуст түрэмгийлэгч, эвдлэн сүйтгэгч хэмээн дүрсэлсэн бол, хоёр дахь хэвлэлд тодорхой хэмжээнд засвар хийж, тусгаар улсыг үндэслэгч хэмээн үнэлсэн байна. Гурав дахь хэвлэлд харин Чингисийг анхны хэвлэлтэй бараг адил агуулгаар дүрсэлжээ.

Үнэн хэрэгтээ БНМАУ-ын түүхийн эмхэтгэл, 1962 онд тохиосон Чингис хааны мэндэлсний 800 жилийн ой нь Монголд үндсэрхэг үзлийн суурь бүрэлдэхэд томоохон нөлөө үзүүлсэн гэж хэлж болно. Түүнчлэн ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн архивт хадгалагдах “БНМАУ-ын түүх”-ийг эмхэтгэхэд Монгол-ЗХУ-Хятад улсуудын хооронд илгээсэн албан бичиг, 1962 онд болсон Чингис хааны мэндэлсэн 800 жилийн ойн баяртай холбоотой түүхийн сурвалж бичгийг олж үзэх завшаан зохиогчид тохиосон юм. Ийнхүү тус өгүүлэлдээ “БНМАУ-ын түүх”-ийн анхны хэвлэл, хоёр дахь хэвлэлийг эмхэтгэх үйл явц, Чингисийг хэрхэн дүрсэлж байсан талаарх номын агуулга, 800 жилийн ойн баярыг тэмдэглэх үе шат зэрэг үйл явдлыг багтаан 1954-1966 оныг судалгааны гол хугацаа болгон үзсэн билээ.

ЗХУ-ын удирдлага дор үндэсний түүх бичгээ эмхэтгэх явцад Монголын сэхээтнүүдийн хэрэгжүүлсэн тактик (1954-1966 он)

Гол асуудалд шилжихийн өмнө ХХ зууны эхэн хагаст Чингисийг хэрхэн дүрсэлж байсан талаар товч өгүүлье.

Орчин үежлээс өмнө монголчууд Чингисийг буддын шашны бурхан сахиус,¹⁶ эртний домогт гардаг баатар хэмээн үздэг байв. Гэтэл Манж Чин улс нуран унаж, орчин үежил явагдаж эхлэхэд, Чингис хаан, Монголын эзэнт улстай холбоотой ЗХУ болон Өрнөдийн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллүүд болон Марко Пологийн “*Дорнодод зорчсон тэмдэглэл*” зэрэг сонгодог бүтээлүүд монгол хэлнээ орчуулагдсанаар, сэхээтнүүд аажмаар орчин үеийн газар зүй болон түүхийн шинжлэх ухааны үүднээс мэдлэг мэдээлэл олж авах болов.¹⁷ Ялангуяа,

¹⁴ Ш.Нацагдорж (ред.), *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх Тэргүүн боть: Нэн эртнээс XVII зуун*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966.

¹⁵ Ш.Бира, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, А.П. Окладников, С.Д.Дылыков, И.Ш.Казакевич (ред.), *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх нэмж засварласан гурав дахь хэвлэл*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1984.

¹⁶ Herbert Franke, *From Tribal Chieftain to Universal Emperor and God: The Legitimation of the Yuan Dynasty (1978)*, In *China Under Mongol Rule*, Aldershot, Hampshire, UK; Brookfield, Vt., USA: Variorum, 1994, pp. 64-69.

¹⁷ Ц.Цэрэн “Онход Жамбяан Дэлүүн Болдогийг хайсан нь”, *Утга Зохиол Сонин*, No.34 (1990); Б.Энхтүвшин, А.Очир, С.Чулуун (ред.), *Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи*, Улаанбаатар: Admon, 2011, тал 29.

Монголын Нууц Товчоог уран зохиолын бүтээл төдийгүй түүхийн сурвалж хэмээн үзсэн ЗХУ-ын монгол судлаач Борис Владимирцовын “Чингис хан”,¹⁸ “Монголын нийгмийн тогтолцооны түүх” зэрэг ном монгол хэлнээ орчуулагдаад зогсохгүй монголын сэхээтнүүдийн Чингисийг үнэлэхдээ эш татдаг гол сурвалж болов. Америкийн түүхч Кристофер Этвүүдийн хэлсэнчлэн орчин үежлийн үйл явц нь монголчууд аливаа асуудлыг шашин шүтлэгээс ангид, мөн Европын түүхийн шинжлэх ухааны аргаар Чингисийг үзэх ухамсар суусан (secularization and Europeanization of Mongolian historical consciousness)¹⁹ гэж хэлж болох юм. Түүнчлэн Монголд анх удаа орчин үеийн шинжлэх ухааны аргаар түүх бичиг туурвигдсан (А.Амар “Монголын товч түүх” 1934 он).²⁰ Зохиогч ерөнхий сайд асан А.Амарыг харин үндсэрхэг үзэлтэн хэмээн Москвад цаазаар авч²¹ уг номыг нь хоригложээ.

1940-1950-иад оны эхэн хүртэл Оросын эрдэмтэд, зохиолчдын бүтээлийг орчуулснаар Чингисийн дүрийг бүтээх нэгэн үндсэн хэлбэр тогтсон байна. 1941 онд Поздневийн “Монголын эзэнт гүрэн ба Чингис хааны үе”²² номыг Ц.Дамдинсүрэн худам монгол бичигт хөрвүүлэн, хэвлүүлжээ. Гэтэл 1945 оноос бүхий л ном хэвлэлийг кирилл үсгээр хэвлэх болж Монголын ард түмний бичиг үсэг мэдэх чадварыг (literacy) дахин тогтоохоос (reset) өөр аргагүй болжээ.

Дэлхийн II дайнаас хойш ЗХУ-ын нэгэн адил Монголд ч үндсэрхэг үзлийг хавчих үзэгдэл эхлэв. 1948 оны сүүлээр Монголын анхны сурах бичиг болох “Ардын унших бичиг”²³ хэвлэгдсэн боловч ирэх жил нь буюу 1949 оны 3 дугаар сард Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал (тухайн үед 35 настай) тус сурах бичгийг “Чингис хааны дээрмийн аян дайн”²⁴-ыг магтан дуулсан”, “найрсаг бус үндсэрхэг үзэл”²⁵ хэмээн хурцаар шүүмжилж, энэ номын эмхэтгэлд оролцсон хүмүүсийг ажлаас нь чөлөөлөхийн зэрэгцээ тус номыг хориглон устгажээ. Түүний дараа зохиолч Ц.Дамдинсүрэн “Монголын нууц товчоо”-ны өмнөтгөлд социализмын үзэл суртлыг магтан дуулсан үг нэмж бичсэнээр²⁶ кирилл үсгээр хэвлэгдсэн байна.

¹⁸ Монголын ШУА-ын Түүх, Археологийн хүрээлэнгийн Баримтын төв, Ф-3, Д-1, хн-1114.

¹⁹ Christopher P. Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, New York: Facts on File, 2004, p.101.

²⁰ А.Амар, *Монголын товч түүх*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989 (1934), Анандын Амар, *Монголын эх түүх I Монголын товч түүх*, Улаанбаатар: Соёмбо принтинг, 2015.

²¹ Ж. Болдбаатар, *Амар сайд: нэмж засварласан хоёр дахь хэвлэл*, Улаанбаатар: Соёмбо Принтинг, 2016, тал 89-95.

²² Н.Н.Позднеев, Ц. Дамдин-Сурун (орч), *Chinggis Qaghanu üi-e-yin Monggol güren*, Ulaanbaatar: Ulsyn khewlel, 1941.

²³ Ж.Жамсранжав, *Ардын унших бичиг*, Улаанбаатар: Улсын Хэвлэл, 1948.

²⁴ Орос хэлний “грабительские походы (Чингис-хана)” үгийн орчуулга. Орос хэлний “грабительские” тэмдэг нэр нь тонуулч, дээрэмчдийн гэсэн утгатай бөгөөд монгол хэлнээ “дээрэм” хэмээн орчуулсан билээ.

²⁵ УТА УТНОНББАХ-4, Д-16, хн-5, тал 13.

²⁶ Ц.Дамдинсүрэн, “Удиртгал”, Ц.Дамдинсүрэн (орч), Монголын Нууц Товчоо, Улсын Хэвлэлийн Газар, 1990 (1947), тал 9-11.

Түүнчлэн 1950, 1951 онд тус бүр ЗХУ-ын зохиолч Василий Яны туурвисан роман “Чингис хаан”²⁷ (анх 1939 онд хэвлэгдсэн), “Бат хаан” (анх 1941 онд хэвлэгдсэн) номууд орчуулагдав. “Чингис хаан” зохиол ЗХУ-д ихээхэн алдарт хүрч, Герман-Оросын дайн дэгдсэн 1942 онд Сталины шагналыг хүртсэн юм. Энэ зохиолыг хохирогчийн өнцгөөс харж бичсэн бөгөөд, Чингис хааныг харгис хэрцгий, бүдүүлэг, үзэшгүй муухай шуналтай этгээд, Монголын цэргүүд ч өлсгөлөн дүртэй, танхай балмад хүмүүс болгон дүрсэлсэн байна. Гэхдээ тухайн үед нийт 758.000 хүн амтай байсан (1950 он²⁸) Монголд тус ном 10 мянган хувь хэвлэгдэж, олны хүртээл болжээ.

1952 онд удирдагч Х.Чойбалсан Москвад зуурдаар нас нөгчиж, дараа жил нь Сталин ч насан өөд болов. Энэ үеэр албан ёсны түүх болох “БНМАУ-ын түүх”-ийг эмхэтгэх ажил эхэлсэн билээ. Нэрэн дээрээ Монголын ШУА, ЗХУ-ын ШУА-ийн хамтарсан ажил гэсэн авч үнэн хэрэгтээ ЗХУ нь БНМАУ-ын дотоодын түүхийн асуудалд хөндлөнгөөс оролцсон хэрэг байв. Ялангуяа анхны хэвлэлд (орос хэлээр 1954 онд, монгол хэлээр 1955 онд хэвлэгдсэн) Чингисийг “нүүдэлчдийг дарлан мөлжигч, харийн улсуудын хувьд цуст түрэмгийлэгч, эвдлэн сүйтгэгч” хэмээн дүрсэлсэн байна. Яны зохиол болон “БНМАУ-ын түүх”-ийн анхны хэвлэлд түүнийг социалист үзэл суртлаар тайлбарлах боломжгүй, нэг төрлийн мангас болгож (demonize) бичсэн гэж хэлж болно.

1954, 1955 оны анхны хэвлэлийн арын хуудсыг харахад, Москвад 1954 оны 10 сарын 26-нд орос хэлээр хэвлэгдэж, тухайн жилийн 9 сарын 22-ны өдөр монгол хэлээр эх бэлтгэлд өгч, 1955 оны 4 сард Улаанбаатар хотноо хэвлэгдсэн болохыг харж болно. Үнэндээ саяхныг хүртэл маш нууцын зэрэглэлтэй байсан Улсын төв архив дахь түүхийн материалыг үзсэн Д.Өлзийбаатарын хэлснээр, тус номын анхдугаар эмхэтгэлийн хурал “Ардын сурах бичиг”-ийг шүүмжилсэнтэй бараг зэрэг буюу 1948 оны 12 сард зохион байгуулагдаж, дээрх хурлаар орчин үеийн түүхээс бусад, ихэнх хэсгийг ЗХУ-ын эрдэмтэд бичихийг шийдвэрлэсэн гэжээ. Чингисийн амьдарч асан дундад зууны түүхийг ч ЗХУ-ын Козин, Якубовский нар бичсэнийг орчуулан эмхэтгэжээ.²⁹ Мөн орос хэлээр 10.000 хувь, монгол хэлээр 25.000 хувь хэвлэгдсэн байна (1955 онд Монгол 827.000 хүн амтай байсан³⁰).

²⁷ В.Ян, Дамдинсүрэн (орч.), Нацагдорж (орч), Ринчин (орч) ба бусад, И.Ринчин (ред), *Чингис Хаан*, Улаанбаатар: Сүхбаатар нэрэмжит улсын хэвлэх үйлдвэр, 1950.

²⁸ National Statistical Office of Mongolia, *Mongolian Population in XX Century*, Ulaanbaatar: National Statistical Office of Mongolia. 2003, p.78.

²⁹ Д.Өлзийбаатар, “Бүгд Найрамдах Монгол Ардын Түүх” Нэгэн боть социализмд тохируулсан Монголын түүхийн ном мэндэлсэн нь, Д.Чулуунжав, Д. Батмөнх, Ц.Жаргал (ред.), *Монголын түүх судлал: Философи, шинэ хандлага, тулгамдсан асуудалд: симпозиум илтгэлийн хураангуй*, Улаанбаатар: ШУА-ын Философи, Социологи, Эрхийн хүрээлэн, МУИС-ын Түүхийн тэнхим, Монгол Уламжлалт Академи, 2014, тал 26-51.

³⁰ National Statistical Office of Mongolia, *op.cit.*, p.78.

Тус номын монгол хэлээрх хэвлэл нийт 539 хуудастай, Тэмүүжин-Чингис хаан ба Их монгол улстай холбоотой тэмдэглэл 31-хэн хуудас байна. Чингис Монголын олон овог аймгийг нэгтгэсэн талаар бичихдээ эцэг Есүхэйн үхлээр эхэлж, Жамуха, Ван хааныг унагааж, 1206 онд хаан ширээнд суух хүртэл ердөө хоёрхон хуудас бичигдсэн байна. “Монголын нууц товчоо”-нд дүрсэлсэн бага насандаа туулсан зовлон зүдгүүрт он жилүүдийн талаар огт дурдаагүй. Түүний дараа Чингис хааны гадаад аян дайны талаар 4 хуудас, түүний залгамжлагчдын гадагшаа хийсэн аян дайны талаар ч нийтдээ 12 хуудас л бичсэн байна.

Агуулгаас үзэхэд, юуны өмнө Тэмүжиний нөхөр³¹ байсан шадар туслах жанжинуудаа цуглуулсан талаар “*нөхөр гэдэг бол ноёдын нөхөр хамсаа, шадар зарц*”, “*нөхрийн алба нь феодалын мөлжлөг ба боолчлолыг эсэргүүцсэн жирийн нүүдэлчний эсэргүүцлийг дарах байсан*” хэмээн дүгнэжээ. Үүний нотолгоо болгож, нөхрүүд “олон дайн тулаанд явж, үзэсгэлэнт эмс охидыг булаан, хүлэг морьдыг нь бариад өргөн барья” хэмээх “Монголын нууц товчоо”-ны хэсгийг эш татсан байна.³² Мөн Чингис хааны гадаад аян дайныг “Дээрмийн аян дайн” хэмээх тусгай зохиогдсон үгээр тайлбарлажээ. Ялангуяа Хорезмын нийслэл Самарканд хот эзлэгдсэн талаар бичихдээ, хэтрүүлэг ихтэй тус хотын иргэдийг өмгөөлөн бичсэн бараг л тэднийг төлөөлөн хэлсэн үг мэт.

*(Самарканд) хотын иргэд төрж өссөн энэ хотоо чин зүрхнээсээ хайрладаг болохыг эзлэн түрэмгийлэгчдэд харуулсан. Улмаар тэвчээртэйгээр, баатарлагаар Самаркандыг хамгаалсан юм. Чингис хааны арми хэдэн мянган хүнийг алж, 4-5 сарын турш бүсэлж байж энэхүү Хорезм хотыг эзэлсэн. Тэд үзэн ядалтаар амьдарч, амьтай голтой бүхнийг хороож байв.*³³

Энэ тэмдэглэлийг ямар сурвалж бичигт тулгуурлан бичсэн талаар тус номд ч, орос хэлээрх эх хувилбарт ч байхгүй.³⁴ Мөн Чингис хааны гавьяаг ийнхүү дүгнэжээ.

*(Чингис нь) бүх монгол үндэстний хүчийг Ази, Европ, түүнээс бусад ард түмнийг боолчлох дээрмийн аян дайндаа чиглүүлсэн байв. Чингисийн эзэнт улс нийтийн эдийн засгийн суурингүй, эзлэн түрэмгийлэхийн төлөөх армитайгаараа онцлогтой бөгөөд Монголын дарлал захиргаанд орсон олон үндэстэн ястныг цуглуулан нэгтгэснээс хэтрэхгүй.*³⁵

³¹ Ташрамд дурдахад, энэ үгийг социализмын үед “анд нөхөр” гэдэг утгаар хэрэглэж байжээ. Өнөөгийн Монгол улсад “нөхөр”, Өвөрмонголд “асран хамгаалагч” гэсэн утгыг ч илэрхийлдэг.

³² Б.Д.Греков, С. А.Козин, Б.Ширэндэв, Ц. Дамдинсүрэн бусад (ред.), *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх*, Улаанбаатар: Улсын хэвлэл, 1955, тал 102-103.

³³ Мөн тэнд, 113-р тал.

³⁴ Б.Д.Греков, С. А.Козин, А.А. Губер, Е.М.Зуков, С.В.Кисерёв (ред.), *История Монгольской Народной Республики*, Москва, Академи Наук СССР, 1954. ст.92.

³⁵ Мөн тэнд 114-р тал.

Харин ЗХУ-ын ШУА-ын Дорно дахины судалгааны хүрээлэн 1954 оны 7 сараас БНМАУ-ын түүхийг 3 боть болгон дахин эмхэтгэх шуурхай төлөвлөгөө боловсруулсан тухайгаа 1955 оны 6 сарын 8-ны өдөр мэдэгдэж, юутай ч гэсэн Монголын талаас хамтран ажиллахыг санал болгов.³⁶ Улмаар ЗХУ-ын тал “1956 оны 1 сард номоо бичиж, 1959 оны 12 сард дуусган, 1960 онд хэвлэх” төлөвлөгөө боловсруулж, А.А.Губер, С.В.Киселев, Л.П.Дүман зэрэг редакторуудыг томилсон байна.³⁷ Харин Монголын ШУА нь юуны өмнө ЗХУ-д чин сэтгэлээсээ талархснаа илэрхийлээд, Монголын эрдэмтэд эмхэтгэлийн ажилд оролцох хүслээ телеграфаар явуулжээ. Харин Монголын эрдэмтэд “1959 он хүртэл тус номыг эмхэтгэн гаргаж амжихгүй учир, 1965 он гэхэд эмхэтгэлийг ажлыг дуусгая” гэсэн санал дэвшүүлсэн байна. Хамгийн сонирхолтой нь, Монголын талаас ЗХУ-д “тус номоо бичихэд Хятадын эх сурвалжуудыг үзэх нь зайлшгүй хэрэгтэй бөгөөд түүнийг монгол хэл рүү хөрвүүлэх ажилд Хятадаас тусламж авах шаардлагатай”³⁸ хэмээн 3 ботийг эмхэтгэх ажилд Хятадын Шинжлэх Ухааны Академийг оролцуулахыг санал болгожээ. Нэг ёсондоо монгол эрдэмтэд ЗХУ-ын заавраар хийгдэж байгаа ажилд Хятад улсыг татан оролцуулснаар ЗХУ-ыг сатааруулах санаатай байсан гэж хэлж болох юм.

Эл саналын хариуд ЗХУ 1956 оны 8 сарын 17-ны 1316 дугаар захидалд “Хятадын эх сурвалж чухал шаардлагатай байгааг ойлгож, Хятадын эрдэмтдийг эмхэтгэлийн ажилд оролцуулахтай санал нэгдэв” хэмээн хариу илгээсэн байна.³⁹

Үүний дараа түүхийн сурвалж бичгээс үзэхэд, 1956 оны 11 сарын 13-19-ний өдөр ЗХУ, Монгол, Хятад 3 улсын түүхчид цугларч, энэ 3 ботийн эмхэтгэлийн хурал зохион байгуулжээ.⁴⁰ Улмаар 1957 оны 12 сарын 9-18-ны хооронд Москва дахь ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахины судалгааны хүрээлэнд ЗХУ, Монгол, Хятад улс дахь Монголын түүхийн судлаач, эрдэмтэд цугларч, Монгол улсын түүхийн 3 улсын хамтарсан хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Энэ хэлэлцүүлэгт ЗХУ-аас 35 судлаач, Хятадаас 3 судлаач 1 орчуулагч буюу 4 хүн, Монголоос 6 хүн (Ширэндэв, Дамдинсүрэн, Нацагдорж, Пэрлээ, Гончигдорж, Сэр-Оджав), нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдав.⁴¹ Хурлаар хоёр дахь хэвлэлийн дотоод бүтцийн талаар ярилцсан бөгөөд анхны хэвлэлд дурдаагүй Тэмүжиний бага насны зовлон зүдгүүр, өсвөр насны тулаан, Нэгдсэн Монгол улс (Единое Монгольское государство) гэсэн бүлгийг нэмж оруулахаар болсон байна.⁴²

Гэтэл 1958 оны 2 дугаар сарын 5-нд Хятадын Соёлын яамны дэд сайд Монголын Соёлын Яамны Сосорбарам сайдтай Бээжинд уулзаж, Монголын

³⁶ Ф-6, Д-1, Хн-7, тал 196-199.

³⁷ Мөн тэнд, 198-199-р тал.

³⁸ Мөн тэнд, 201-р тал.

³⁹ Мөн тэнд, 210-р тал.

⁴⁰ Мөн тэнд, 252-264-р тал.

⁴¹ Мөн тэнд, 149-р тал. Гэвч ЗХУ-ын 35 судлаачийн хоёрынх нь нэр бичигдээгүй.

⁴² Мөн тэнд, 22-23-р тал.

түүхийн эмхэтгэлийн ажилд Хятадын тал цаашдаа оролцохоос татгалзах санаа илэрхийлжээ. Учир нь Хятадын талын бичсэнээр “Түүхийн эмхэтгэлийг хамтран хийх нь ашиг тустай боловч, Хятадад ч феодализм болон капитализм хэзээ байгуулагдсан талаар нэгдсэн үзэл санааг гаргаж чадаагүй, тэр ч байтугай бид өөрийн улсын түүхээ хүртэл бүрэн бичиж дуусгаагүй” хэмээн ярьжээ.⁴³ Цаашлаад, Монгол талын тэмдэглэлээс үзэхэд Жоу Эн Лай ерөнхий сайд ингэж бичжээ.

*Монголын түүхийг 3 улсын хамтарсан хэлбэрээр эмхэтгэн бичихэд манай улс оролцох нь тохиромжгүй. Гэсэн хэдий ч шаардлагатай гэж үзвэл бид өөрт байгаа холбогдолтой сурвалж материалаа бүгдийг үзүүлэхэд бэлэн байна. Нэг улсын түүхийг өөр улсын түүхч бичнэ гэвэл тухайн улсын түүхийн дарааллыг бүрэн төгс хийгээд үнэн зөвөөр үнэлэн дүгнэх боломжгүй болох биз ээ. Мөн түүнд үндэслэн ард иргэдийн дунд буруу, алдаатай түүхийг ойлгох явдал гарах аюултай. Монголын түүхийг бичихэд интернационализм болон монголын үндэсний онцлогийн аль алинд анхаарлаа хандуулах шаардлагатай.*⁴⁴

Үүнээс харахад, ЗХУ-ын заавраар түүх бичгийг эмхэтгэх ажлыг хятадууд шууд бус утгаар шүүмжилсэн болох нь илэрхий байна. Тухайн үед Хятад Оросын сөргөлдөөн (1956 он) дөнгөж эхэлж байсан цаг. Интернационализм нэрийн дор ЗХУ, БНМАУ нь “Хятадын түүх”-ийг ч хамтран эмхэтгэж болох юм хэмээн хятадууд болгоомжилсон байж магадгүй. Юутай ч гэсэн БНМАУ интернационализмаар халхавч хийн, ЗХУ-ын түрэмгийллээс амжилттайгаар мултарсан бол, Хятад улс интернационализмаар далимдуулан өөрсдийнх нь түүх рүү өнгийх вий хэмээн болгоомжилж үүнээс ухарсан. Дашрамд хэлэхэд 1930-аад оноос хятадууд Чингисийг өөрийн соёлын нөөц болгохын төлөө нилээд ажиллаж байсан. Жишээлбэл Мао Зэ Дун өөрийгөө Чингисээс илүү агуу хүн хэмээн магтан дуулсан “Тэнгэрийн хөвгүүн” (1936) бадаг шүлэг бичсэн. Мөн Өвөрмонголын Ордост байдаг Чингисийн онгоныг тухайн үед Хятадын коммунист намын төв байсан Яньань хот руу нүүлгэж тахисан зэрэг⁴⁵ Чингис хааныг Хятадын олон үндэстний нэг буюу Хятадын үндсэрхэг үзэл бүрдүүлэх соёлын нөөц болгон ашиглаж эхэлсэн⁴⁶ болохыг анхаарах нь зүйтэй.

⁴³ Мөн тэнд, 157-160-р тал.

⁴⁴ Мөн тэнд, 159-р тал.

⁴⁵ Японд ажилладаг Өвөрмонголын антропологич Ян Кай Ин (Оонос Цогт) “Чингис хааны тахилга-туришлтаар түүхэн антропологиог дахин бүтээх нь” Фүкёошя, 2004 он, тал 301-303. Пао Мүпин “Монгол дахь хот барилгын түүхэн судалгаа-нүүдлийн ба суурин соёл давхацсан хот-Хөх хот” Тоохоо шётэн, 2005 он, тал 267. (Yan Hai Ing, “Chingis haan saishi- kokoromi toshite no rekishi jinnruigakuteki saikoosei, Fukuyosha, 2004, pp 301-303. Pao mupin, “Mongoru ni okeru toshi kennsetsushi kenkyu-yuboku to teijyu no jyusoo toshi Huhuhoto”, Toohoo shoten, 2005, pp 267)

⁴⁶ Мөн тэнд, 304-р тал.

Ийнхүү явсаар хэвлэгдэн гарсан “БНМАУ-ын түүх”-ийн хоёр дахь хэвлэлийн 3 боть ном 1966 оны 4 сард 10.000 хувь хэвлэгдсэн ба уг номонд Чингис хаантай холбоотой тэмдэглэл анхны хэвлэлээс тэс ондоо болсон байна. Юуны өмнө, Чингис ба Их Монгол улсын талаарх түүхийг 1-р ботид багтаажээ. 1-р боть нь тэргүүн, дэд хоёр хэсэгтэй, 6 бүлэг, 24 дэд хэсэгтэй, Тэргүүн хэсэгт эртний түүхийг номын гуравны хоёрт бичиж, дэд хэсэгт Их Монгол улсын түүхийг оруулжээ (167-470 хуудас). Мөн гарчгийн хувьд, дэд хэсгийн 1-р ангийг “Монголын феодалын нэгдсэн улс” хэмээн нэрлэж, Чингис хааны гадаад аян дайныг ч 3-р бүлэгт “Чингисийн байлдан дагуулал-Монгол гүрэн” зэргээр өмнөх хэвлэлд байсан “дээрмийн аян дайн” гэх мэтийн сөрөг нэр томъёог хассан байна. Мөн анхны хэвлэлд, Чингисийн эзэнт гүрнийг “улс төрийн бүтэцгүй, энд тэндээс цугларсан дээрмийн бүлэг” хэмээн үзсэн бол 1966 оны хоёр дахь хэвлэлд, 2-р бүлгийн 4-т “Монгол Улсын улс төрийн байгууламж” хэмээх гарчигтайгаар 13 хуудаст тайлбарласан байна.

Түүнчлэн, Тэмүүжиний мэндэлсэн, түүний бага насны талаар анхны хэвлэлд огт дурдаагүй бол хоёр дахь хэвлэлд “Монголын нууц товчоо”-нд үндэслэн, нийт 43 хуудсанд багтаан дэлгэрэнгүй танилцуулжээ.

Агуулгын хувьд, эхлээд Чингис хааны төрсөн жилийг Мин улсын үед (1368-1644 үе) бичигдсэн “Юань улсын судар”-д үндэслэн “1162 оны зун” хэмээн, төрсөн газрыг “Монголын нууц товчоо”-ны дагуу “Хэнтий аймгийн Онон голын Дэлүүн болдог гэдэг газарт Есүхэй баатрын гэргий Өүлүн эхийн хүү болон мэндэлсэн”⁴⁷ хэмээн тэмдэглэжээ.⁴⁸

Харин энэхүү хоёр дахь хэвлэлийн чухал шинэчлэл нь анхны хэвлэлд бичигдээгүй түүний төрсөн газрыг өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрт оруулж, эцэг эхийн нэрийг нь тэмдэглэсэн⁴⁹ гэдэгт оршино. Ялангуяа хоёр дахь хэвлэл нь “Монголын нууц товчоо”-д бичигдсэнээр, 9 настайд нь эцэг нь Татаарын дайснуудад хорлогдсоноор, овог аймгууд таран бутарч, ахуй амьдрал ч хүндхэн болсон талаар дүрсэлсэн байна. Тухайлбал, Өүлүн хатан, Тэмүүжин нар язгууртнуудын үлдээсэн есөн адуутай үлдэж, тарвага зурам агнаж, загас барьж, хоол хүнсээ залгуулдаг байсан талаарх яриаг дурджээ. Ингэснээр “Монголын нууц товчооны түүх нэг талаараа домог ярианы шинжтэй хэдий ч

⁴⁷ Ш.Нацагдорж (ред.), *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх тэргүүн боть Нэн эртнээс XVII зуун*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966.

⁴⁸ Мөн тэнд, 203-р тал. Гэвч энэ номын тайлбарт “Судрын чуулган”-ыг 1155 онд, “Монголын Нууц Товчоо”-г 1262 онд (1162 оны хэвлэлийн алдаа юу), 1167 оны тайлбар зэргийг дурьдаж болно.

⁴⁹ Чингисийн мэндэлсэн газрын талаар, өнөөгийн ОХУ-ын Забайкаль нутаг (хуучин Чита муж) зэрэг олон маргаан байдаг ч Судар бичгийн хүрээлэнгийн Жамъян ноён 1928 оны Дэлүүн болдог-Дадал тайлбар (Монгол улс дахь тайлбар)-ыг онцолсон. Энэхүү өгүүллээ дээрх тайлбарт тулгуурлан бичсэн билээ. О.Жамъян, *Дэлүүн Болдогийг сурвалжилсан нь*. Улаанбаатар: Шинжлэх Ухаан Дээд Боловсролын Хүрээлэн, 1958 (1928).

*Есүхэй баатрын гэр бүл ядуу зүдүү амьдарч байсан нь үнэн байжээ*⁵⁰ хэмээн дүгнэжээ. Өөрөөр хэлбэл анхны хэвлэлд Тэмүүжинийг хөрөнгөтөн феодалын хүүхэд гэснээс өөрөөр бичээгүй байсан бол, хоёр дахь хэвлэлд харин ч ядуу зүдүү амьдралаас амжилтад хүрсэн хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Мөн түүнээс гадна, *“Өүлэн хатан хэдий ядуу зүдүү амьдарч байсан ч, үр хүүхдээ жинхэнэ язгууртан ёсоор өсгөн хүмүүжүүлсэн”* хэмээн өндрөөр үнэлэхийн зэрэгцээ *“Тэдний дотроос Тэмүүжин бусдаасаа илүү их эзэнлэг догшин болж өсөж торнин.....”* хэмээн, шалтгааныг нь дүүгээ хөнөөсөн домгоор тайлбарлажээ. Нөгөө талаар *“зориг самбаатай учраас Тэмүүжин ард олны дунд алдар хүнийг олсон”*⁵¹ гэхчлэн Чингисийн сайн, муу талыг эн тэнцүү тэмдэглэн бичсэн байна.

Түүнчлэн анхны хэвлэлд огт дурдаагүй анд нөхөр Жамухтай танилцан, нөхөрлөж, тангараг тасарсан талаарх явдал, Тоорил вантай нэгдсэн зэрэг Монголыг нэгтгэх хүртэлх түүхийг хоёр дахь хэвлэлд *“Монголын нууц товчоо”*-ноос эш татан бичжээ.

Бас нэг сонирхолтой зүйл нь, нөхөр буюу шадар туслахын талаар анхны хэвлэл дэх *“шадар туслах буюу нөхрийн үүрэг нь феодалын мөлжлөг, анги давхаргыг эсэргүүцсэн нүүдэлчдийг дарах байсан”* зэрэг сөрөг утгатай тэмдэглэлийг хасжээ. Үүний оронд Тэмүүжин 1189-1206 он хүртэлх 20 жилийн хугацаанд Монголын олон ханлиг аймгийг нэгтгэж чадсан шалтгаан нь нөхөр, анд нарын дэмжлэгтэй холбоотой хэмээн үзсэн байна. Улмаар тэрхүү нөхөр, андын талаар *“хөрөнгө ихтэй, баян чинээлэг хэсэг бүлэг нүүдэлчин”* бөгөөд *“тэдний дэмжлэг тусламж монгол үндэстнийг нэгтгэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэн”*⁵² хэмээн эергээр үнэлсэн байна.

Мөн, Чингисийн гадаад аян дайн, ялангуяа Самаркандыг эзэлсэн талаар ч, Монголын армийн харгис хэрцгий байдал төдийгүй Чингис тухайн хотыг түрэмгийлэн эзэлсэн шалтгааныг бодитоор тайлбарлажээ.

Тэр үед Самарканд хотыг 110 000 шилдэг цэрэг хамгаалж байжээ. (товчлов). Хот хамгаалах ажлыг Мухамед шахын эх Туракина хатны дүү Тугай хан гэгч удирдаж байжээ. Самарканд хотын иргэд хотоо хамгаалан тэмцсэн боловч Тугай хан хотыг хамгаалах талаар олигтой ажил хийж чадахгүй байсан ба хотын доторх цэрэг урваж Чингисийн талд оржээ. Монгол цэрэг хотыг бүслэн довтолсон өдрөөс эхлэн хотын ихэс лам нар⁵³ том сайд түшмэд, баячууд мөн л Чингист бууж өгөхөөр төлөөлөгчдөө хотын ард түмнээс нууцаар удаа дараа сэм

⁵⁰ Мөн тэнд, тал 203.

⁵¹ Мөн тэнд.

⁵² Мөн тэнд, 212-р тал.

⁵³ Энд “ulama” буюу ислаам шашны эрдэмтнийг хэлсэн байна.

илгээж байсан байна. Монгол цэрэг таван өдөр ширүүн дайн хийсний дараагаар Самаркандыг эзлэн авч, эд баялгийг тонон дээрэмдэж, гурван түм орчим уран дархчуудыг олзлон авчээ. Хотын бусад иргэдийг хядахыг нь хядаж боол болгохыг нь болгожээ. Хятад газраас Чингис хааны урьсан ёсоор уулзахаар Самарканд хотыг дайран гарсан Чан Чуны тэмдэглэлд тэр үед “Самарканд хотод амьд үлдсэн хүн ам түрүүчийн бүх хүн амын 4-ний 1 хувь байсан” гэж бичсэн байна.⁵⁴

Самаркандыг эзэлсэн энэхүү дайны талаар анхны хэвлэлд сурвалж бичгийн баримтыг үл тоон, хотын иргэдийн “тэвчээртэй баатарлагаар тулалдаж хотоо аварсан”, “хотдоо чин зүрхнээсээ хайртай болохыг эзлэн түрэмгийлэгчдэд харуулсан” учраас монголчууд “хэтэрхий үзэн ядсандаа амьтай голтой бүхнийг алж устгасан” зэргээр орос эрдэмтэд хэт хийрхий бичсэн байсан. Гэтэл хоёр дахь хэвлэлд үнэн хэрэгтээ Самарканд цайз дотор урвагч байсан талаар, бүх хүнийг хороосон бус уран дархчуудыг олзлон авч үнэндээ 3/4-ыг нь хороосон талаар “Судрын чуулган”, “Чан Чун бумбын баруун газар зорчсон тэмдэглэл”-ээс эш татан, бодитоор тэмдэглэн бичжээ. Ийнхүү ЗХУ-ын эрдэмтдийн эш үндэслэлгүй тайлбарыг засахын тулд эмхэтгэлийн ажлын явцад Хятадын талаас өгсөн түүхэн сурвалж бичиг (Чан Чун бумбын баруун газар зорчсон тэмдэглэл) ихээхэн тус болсон нь дамжиггүй.

Харин хамгийн сүүлд Чингис хааны гавьяа зүтгэлийг “Чингис хүч чадлаа язгууртан ангийн төлөө зориулсан”, “феодализмыг тогтоон, ард иргэдийг хавчин, дарлан захирч байсан”⁵⁵ хэмээн социалист үзэл суртлаар дүгнэжээ. Гадаад аян дайны талаар ч урьдын адил сөргөөр дүгнэн бичсэн байна.

Чингис нь монголын олон тархай бутархай аймаг улсуудыг нэгтгэж нэгэн улсын хүрээнд оруулан, монголын үндэсний төр бүрэлдэн тогтоход түүнийг анх үүсгэн байгуулагчийн хувьд зохих үүргийг гүйцэтгэсэн боловч 1211 оноос эхлэн бусдын газар орныг булаан дээрэмдэх дайныг өргөн хэмжээгээр явуулсан бөгөөд чухамхүү энэ үеэс эхлэн Чингисийн үйл ажиллагаа нь эрс харгис шинж чанартай болсон юм. Чингис тэргүүтэй монголын байлдан дагуулагчдын дээрмийн аян дайн нь Ази, Европын ард түмэнд цаглашгүй их үхэл гамшиг, эвдрэл сүйрлийг учруулж, түүхийн үнэлж баршгүй хосгүй нандин зүйлийг сүйтгэн, тэдгээр орны хөгжлийг асар ихээр хойш татсан юм. (товчлов).

⁵⁴ Мөн тэнд, 234-р тал.

⁵⁵ Мөн тэнд, 240-р тал.

Чингисийн явуулсан булаан эзлэх дээрмийн дайны шинж чанарыг К.Маркс “Тэд (монголын байлдан дагуулагчид) явсан газар бүхнээ ээрэм цөл болгож, өн үржилт нутаг, хүн суусан тосгон сууриныг үнсэн товрог болгож хувиргасан”

гэж заажээ.⁵⁶

Гэхдээ 1966 оны хоёр дахь хэвлэл ийнхүү бичсэний дараа ЗХУ-ын түүхч А.П.Петрушевскийн “алан хядах зохион байгуулалттай системийг дээрээс Чингисийн шууд зарлигаар явуулжээ. Энэхүү систем нь монголын ба тэдэнтэй нийлсэн түрэг нүүдэлчин аймгуудын язгууртан нарын сэтгэл санаанд нийлжээ” хэмээх санааг шүүмжлэн бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тус ном нь “Чингисийн үр хүүхдүүдийн дунд ч харгис аллагыг эсэргүүцсэн хүн байсан”, “Өгөөдэй хааны жилүүдэд дээрх аллага эрс цөөрсөн” зэрэг эерэг жишээг иш татан, Петрушевскийн үзлийг шүүмжилсэн байна.⁵⁷ Хамгийн сүүлд ийнхүү дүгнэж бичжээ.

*Энэ харгис хэрцгий явдлыг XIX зууны үеийн өрнөд европын зарим эрдэмтэд монголын ард түмний “арьсны чанар” мэтээр тайлбарласанчлан монголын ард түмэнд харгис хэрцгий явдлын гэм бурууг ноогдуулах ямар нэгэн үндэс бидэнд бүр ч үгүй юм.*⁵⁸

“Өрнөд европын зарим эрдэмтэд” хэмээх үгийг оруулснаар ЗХУ-ыг шүүмжлээгүй гэдгээ дурдахын зэрэгцээ, Европ ба ЗХУ далдуур Чингис хаан ба Монголын эзэнт гүрнийг мангасын орон мэт харагдуулж байгааг тухайн үеийн Монголын эрдэмтэд эсэргүүцэж байсан санаа нь цухас харагдаж байгаа юм.⁵⁹

Юутай ч, ЗХУ-ын эрдэмтдийн бичсэн анхны хэвлэлтэй харьцуулахад харин ч Нацагдорж ахлагчтай Монголын эрдэмтдийн бичсэн хоёр дахь хэвлэл нь хэдийгээр ЗХУ, Хятадын хамтран бичсэн түүхийн тэмдэглэл гэж байгаа ч түүхийн эх сурвалжид тулгуурлан Чингисийг эерэг утгаар нь тэмдэглэн үлдээсэн болох нь ойлгомжтой. Харин Чингисийн гавьяа зүтгэлийн талаар дүгнэхдээ үнэлэлт ба шүүмжлэл нь хэт нэг тал руу давамгайлалгүй эн тэнцүү орсон байгаа нь ЗХУ ба Монголын эрдэмтдийн дунд өрнөсөн хүнд хэлэлцээрийн үр дүн болов уу хэмээн таамаглаж байна.

Эцэст нь нэмж хэлэхэд, анхны хэвлэлд голдуу орос хэл дээрх сурвалжаас эш татаж, хятад хэлээрх сурвалжийг орос хэл дээрх хувилбараар дамжуулан

⁵⁶ Мөн тэнд, 241-р тал.

⁵⁷ Мөн тэнд, 241-242-р тал.

⁵⁸ Мөн тэнд, 242-р тал.

⁵⁹ Монголын сэхээтнүүд “Шар арьстны аюул (yellow peril)”, Японы “Ёшицүнэ Чингис хаан байсан” зэрэг тайлбарыг XX зууны эхээр аль хэдийнээ мэдэж байсан бололтой. В.К.Фон Нохарагийн бичсэн “Шар арьстны онол” (von W.K.Nohara, Die “Gelbe Gefahr”: Japan und die Erhebung der farbigen Völker, Stuttgart: Union Deutsche Verlagsgesellschaft, 1936. Такахаши Тэрүёши (орч), “Шар арьстны аюул-Япон, Хятад сэрсэн нь, Кокүшё канкоокай, 2012) –ийн нэг хэсэг (Чингис хаантай холбоотой хэсэг) нь герман хэлнээс орчуулагдсан. Гэвч яг хэдэн онд орчуулагдсан нь тодорхойгүй. Ф-4, Д-1, хн-97.

ашигласан бол, хоёр дахь хэвлэлд өрнөдийн англи, герман хэл дээрх сурвалжаас гадна хятад хэлээрх түүхийн сурвалж, бүр япон хэл дээрх эрдэм шинжилгээний өгүүллээс хүртэл (тухайлбал Озава Шигэо, Мураками Масацүгү зэрэг хүмүүсийн өгүүллийг нэрлэж болно) нягтлан үзсэн байна. Гэхдээ 1966 онд 10.000 ширхэг хэвлэгдсэн хоёр дахь “БНМАУ-ын түүх” номыг хэдэн хүн чухам уншсан нь тодорхойгүй. Зохиогч хээрийн судалгааныхаа үеэр сэхээтнүүдийг эс тооцвол, социализмын үед дээрх 3 ботгийг энгийн монголчууд уншсан тухай ярихыг сонсоогүй юм. Шалтгаан нь энэ ном хэвлэгдэхээс 4 жилийн өмнө Чингисийн талаарх яриа дарагдах маш том хэрэг гарсантай холбоотой гэж үзэж байна.

Чингис хаан мэндэлсэн 800 жилийн ойн баяр (1962 он), түүний сөрөг үр дагавар (1962 оноос хойш)

Энэ бол 1962 онд Чингис хаан мэндэлсэний 800 жилийн ойн баяртай холбоотой хэрэг билээ. Монголын ШУА-ийн эрдэмтэд тухайн жил Чингис хааны мэндэлсэн 800 жилийн ойн баярын арга хэмжээ хийхээр төлөвлөжээ. Энэ талаар урьд нь намд алба хашиж байсан түүхч Ж.Болдбаатарын номд дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг.⁶⁰ Тэрээр хэлэхдээ, тухайн үеийн Монголын сэхээтнүүд бүгд Чингис хааны мэндэлсэн ойн баярыг тэмдэглэх хүсэлтэй байсан ч “үндсэрхэг үзэлтэн” хэмээн шүүмжлүүлэхээс айсандаа энэ талаар ярихад зориг хэрэгтэй байсан гэжээ.

Энэ үеэр Хятад улсад Чингисийн мэндэлсэн 800 жилийн ойн баяр хийхээр төлөвлөж байгааг тэнд суралцаж байсан монгол оюутнууд ШУА-ын Түүхийн хүрээлэнд мэдэгдэхэд⁶¹ Монголын эрдэмтэд зориг орсон байна. Ингээд шууд Монголд ч ойн баярыг тэмдэглэхээр зориг шулуудсан ажээ.⁶² Энэ арга хэмжээ нь Хятадыг гайхуулан хэдхэн сарын богинохон хугацаанд амжилттай өрнөсөн гэж хэлж болно.

1962 оны 1 сарын 8-нд Түүхийн хүрээлэнгийн захирал Д.Цэдэв МАХН-ын Төв Хорооны суртлын хэлтсийн эрхлэгч Ж.Цэдэнжаваас Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойн баярыг тэмдэглэх зөвшөөрөл хүсэхийн зэрэгцээ ЗХУ-ын Азийн улсуудыг судлах институтын Монгол, Солонгос, Вьетнамын тасгийн ахлагч С.Д.Дылыковт захиа бичиж, Чингисийн 800 жилийн ойг тус институт тэмдэглэх эсэх, хэрэв тэмдэглэвэл ямар хэлбэрээр яаж зохион байгуулах гэж буй тухай санал, зөвлөгөө өгөхийг хүсжээ.

Түүний дараа 2 сарын 8-нд болсон МАХН-ын Төв хорооны Улс Төрийн Товчооны хуралдаанд Д.Төмөр-Очир энэ баярыг зохион байгуулах төлөвлөгөө

⁶⁰ Ж.Болдбаатар, *Чингис Хаан-800: Үндэсний ухамсрын сэргэлт, дарамт, хавчилт*. Улаанбаатар: Соёмбо Принтинг, 2012.

⁶¹ 1961 оны 12 сарын 5-нд ШУА-ын Түүхийн хүрээлэн Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Ф.23, д.2, хн.415, х.2.

⁶² Мөн тэнд, тал 8.

танилцуулжээ. Эцэстээ МАХН-ын Төв хорооны Улс төрийн Товчоо “*Монгол аймгуудыг нэгтгэж, тулгар төрийг үндэслэн байгуулснаар Монголын түүхэнд дэвшилттэй үүрэг гүйцэтгэсэн Чингисийн төрсний 800 жилийн ойн баярыг 1962 оны 6 сарын 10-нд тэмдэглэн өнгөрүүлэхээр БНМАУ-ын ШУА-аас оруулж байгаа саналыг зөвшөөрсүгэй*” хэмээн шийдвэрлэжээ.⁶³

Намын төв хорооны Улс төрийн Товчооны шийдвэрээр, Чингисийн төрсөн нутагт хөшөө босгох, түүний тухай баримтат кино бүтээх, марк хэвлэх зэрэг ажлууд хийхээр шийдвэрлэв. Сонирхолтой нь Чингисийн төрсөн өдөр чухам хэдийд вэ гэсэн асуудал үлдэв. Үнэндээ, Чингисийн хэзээ мэндэлсэн талаар үнэн бодит тэмдэглэл үлдээгүй юм. Тухайн үеийн монголчуудад төрсөн өдрийг тэмдэглэн үлдээх заншил байгаагүй хэрэг. Ингээд түүхч эрдэмтэд Монголын буддын шашны төв Гандантэгчэнлин хийдэд одон гарагийн зурхайч нарыг цуглуулан, Чингис хааны мэндэлсэн өдрийг 1162 оны 5 сарын 31-ний үүрийн 6 цаг хэмээх тогтоов. Энэ өдөрт үндэслэн, МАХН-ын Төв хорооны Улс төрийн Товчоо ч 800 жилийн ойн баярыг 5 сарын 31-нд зохион байгуулахаар тогтоосон байна.

Ийнхүү 5 сарын 31-ний өдөр ШУА-ын Түүхийн хүрээлэнгээс Чингис хаан мэндэлсний 800 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулав. Хамгийн анх дээрх хурлыг Засгийн газрын ордны их танхимд зохион байгуулах төлөвлөгөөтэй байсан ч эцэстээ засгийн газар оролцохгүйгээр, Төв номын сангийн 106 тоот хурлын танхимд хийхээр болжээ.⁶⁴ Гэтэл хурал эхлэхээс 1 цагийн өмнө Москвагаас ирсэн цахилгаанд ЗХУ-ын эрдэмтэн И.М. Майскийн бичсэн Чингис хааны талаарх өгүүлэл ирэв. Мэргэжлийн түүхч биш, газарзүйн салбарын эрдэмтэн И.М.Майский онцгойлон Чингисийг шүүмжилсэн өгүүлэл бичсэн нь ЗХУ-аас монголчуудад хандсан анхааруулга гэдэг нь тодорхой.⁶⁵ Гэхдээ хурал төлөвлөсний дагуу болж өнгөрсөн юм. Танхимд дүүрэн оролцогчидтой, орж чадаагүй хүмүүс Төв номын сангийн гол хаалганы урд талын Сталины хөшөөний өмнө зогсоод, гадна цагаан хоолойгоор хурлын ажиллагааг сонсоцгоож байсан гэдэг.⁶⁶

Хурал Монголын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Ширэндэв нээж үг хэлснээр эхлэв. Дараа нь “БНМАУ-ын түүх”-ийн хоёр дахь хэвлэлийн Монголын эзэнт гүрний түүхийн талаарх хэсгийн редактор, түүхийг бичсэн академич Ш.Нацагдорж “*Чингис бол Монголын тулгар төрийн үүсгэн байгуулагч*” гэж хэлэхийн зэрэгцээ “*түүний авьяас чадвар нь хэчнээн суут боловч, Чингис бол өөрийн үеийн хүү, өөрийн ард түмний хүү юм. Ийм учраас өөрийн үед, өөрийн орчинд ажиллаж байснаар нь үзэх хэрэгтэй. Харин түүнийг өөр оронд*

⁶³ Мөн тэнд, тал 10-11.

⁶⁴ Мөн тэнд, 18-р тал.

⁶⁵ С.Чулуун, “Чингис хаан оросын судлаачдын нүдээр: Түүхийн судалгаа ба үнэлэлт” Ц.Цэрэндорж (ред.), *Чингис Хаан дэлхийн түүхнээ*, Улаанбаатар: Бэмби сан, 2012, тал 245.

⁶⁶ Болдбаатар, *op.cit.*, тал 23.

шилжүүлэн авчирч үзэж болохгүй” хэмээх ЗХУ-ын эрдэмтэн Владимирцовын саналыг дэмжиж байгаагаа илэрхийлэв. Улмаар “Чингис ардын баатар ч биш, үлгэр домгийн хүн ч биш, харин феодалжиж байсан Монголын язгууртнуудын нэг бөгөөд бүхий л хүчээ язгууртны эрх ашгийн төлөө зориулсан хүн” хэмээн өгүүлж, Чингисийн гадаад аян дайны талаар ч “Европ, Азийн олон орны ард түмэнд зовлон гаслан учруулсан догшин байлдан дагуулагч гэж түүхэнд орсныг мартаж ёсгүй” гэж тэмдэглэжээ. Гэхдээ хамгийн сүүлд “Чингисийн нэр алдар Монголын төрийн тусгаар тогтнолын цаашдын тэмцлийн түүхтэй салшгүй холбоотой явж ирсэн байна. Манай ард түмний сэтгэл зүрхэнд Чингис хаан бол Монголын тулгар төрийг үндэслэн байгуулагч гавьяат хүний дүрээр уламжлагдан хадгалагдаж үлдсэн байна. Энэ нь зүй ёсны хэрэг юм” хэмээн дүгнэсэн байна.⁶⁷

XX зууны эхэн үеийн Монголын энгийн иргэд Чингисийг “Монголын тулгар төрийг үндэслэгч” хэмээн ойлгож байсан эсэх нь эргэлзээтэй. Гэхдээ Ш.Нацагдорж зөвхөн тулгар төрийг үндэслэгч гэдэг утгаар нь онцолсон ба, түүний эзлэн түрэмгийллийг ч эсэргүүцсэн учраас хэт үндсэрхэг үзэлтэй зүйл ярьсан гэж үзэх аргагүй.

Монголын крилл цагаан толгойг зохиосон зохиолч, академич Ц.Дамдинсүрэн ч уран зохиолын байр сууринаас Владимирцовын Чингисийн талаарх үзэлтэй санал нэгдсэн байна. Сонирхолтой нь, өөрийн орчуулсан ЗХУ-ын зохиолч Василий Янгийн “Чингис хаан” зохиолыг “арьс өнгөөр ялгаварласан зохиол” хэмээн хурцаар шүүмжилж

*Зөвлөлтийн зохиолч Ян, “Чингис хаан” гэдэг романд өгүүлэн буй хүн бол жинхэнэ Чингис биш. Зүгээр нэг бүдүүлэг дайсан. Зөвлөлтийн эсрэг Германчууд довтлоход ард түмнийг нэгтгэх боловсрол шаардлагатай болсон. Гаднын дайсан хүрч ирэхэд улс дотроо хагарал үймээнтэй, нэгдэн батжаагүй байх нь ямар аюултай болохыг Ян гайхалтай дүрслэн харуулсныг хэлэх нь зүй. Гэвч Чингис хаан болон түүний тойрон хүрээлэгчдийг сөрөг муу утгаар дүрсэлсэн нь үнэнээс хэт зөрүүтэй байна. Жишээлбэл “Чингис хаан бөөнийсөн муусайн морьдоо унаад жартгай ярдаг хатнаа дагуулаад” гэх зэргээр бичжээ. Чингис хаан бүх Монголыг бүх Азийг эзэлсэн байсан тул аль сайн морийг шилж унаж, аль сайхан хүүхнийг шилж авч явсан юм. Тэгэхээр Чингис хааны хатныг тийм царай муутай, морийг нь тийм өөдгүй юм байсан гэж би итгэхгүй байна. Зохиолч Ян манайхны хар нүдтэй, улаан хацартай хүүхнийг муухай гэж боддог бол, бид тийм хүүхнээ сайхан гэж боддог билээ. Бид баруун зүгийн хонгор үстэй, ногоон нүдтэй хүүхнийг муу муухай гэж ямар ч зохиолдоо яасан ч доромжлохгүй.*⁶⁸

хэмээн бичсэн байдаг.

⁶⁷ Ф-6, Д-1,хн-12, No.7. Үнэн, 1962.5.31.

⁶⁸ Ф-6, Д-1,хн-12, No.4. Ташрамд дурдахад Дамдинсүрэн орос эхнэртэй байсан.

Түүнчлэн дээрх зохиолчийн бичлэгийн хэв маягийг “үндэслэлгүй, учир шалтгаанд нь үнэний хэлтэрхий ч алга. Марксизмын үнэр ч алга” хэмээн шүүмжилсэн.⁶⁹

Үнэхээр л Янгийн дүрсэлсэн Чингисийн дүр марксизмтай огтхон ч хамааралгүй. Тухайн үеийн Монголын эрдэмтэд Чингисийг “тусгаар улсыг үүсгэн байгуулагч” хэмээн үнэлснээс хэтрээгүй нь үндсэрхэг үзэл гэхээс илүү социалист үзэл суртлын хүрээнд багтах үзэл бодол гэж хэлж болно. Харин ЗХУ-ын эрдэмтэд, зохиолчдын гаргасан Чингисийн талаарх үндэслэлгүй “мангас болгон хувиргасан (demonization)” гэмээр гүжир гүтгэлгийг тухайн үеийн Монголын эрдэмтэд бодитоор баримт нотолгоо гарган, логикийн үндэслэлтэйгээр ярьж зассан юм.

Бусад илтгэлүүд ч агуулгын хувьд дээрхтэй адил байв. Тухайлбал, Ш.Бира “Чингисийн Их Засаг (их ясаа) хэмээх хуулийн талаар” ярихдаа “Монгол гүрэн бол зөвхөн эртний овог аймгуудын холбоо нэгдэл төдий бус, харин хатуу чанга хууль цааз бүхий, нэлээдгүй боловсронгуй засаг төр” байсныг онцолжээ. Янгийн зохиолын төгсгөлд насан өндөр болсон Чингис насаа мөнхжүүлэхээр Чан Чун бумбыг урьж байгаа хэсэг гардаг бөгөөд тэнд Чингисийг амьдралд хоргодсон шунал хүсэлтэй дарлагч хэмээн дүрсэлсэн байдаг. Үүнийг Н.Ишжамц Хятадын эрдэмтэн Ван Говэй (王國維)-гийн өгүүлэл болон “Чан Чун бумбын өрнөдөд зорчсон тэмдэглэл” зэргийг эш татан эсэргүүцжээ. Өөрөөр хэлбэл, Чингис Хятадын алдартай эрдэмтэн Чан Чун бумбыг урихдаа Хятад даяар ихэд нэрд гарсан түүнийг биедээ татаж, Хятадыг эзлэхийн тулд түүний улс төрийн нөлөө болон эрдэм мэдлэгийг ашиглах гэсэн гол зорилготой байсан гэж үзжээ.⁷⁰

Энэ хандлага нь Хэнтий аймгийн Дадал суманд Чингис хааны гэрэлт хөшөө босгох үйл явцад ч ажиглагдаж байна. Хөшөөний загварыг зохиосон уран барималч Л.Махвал хамгийн эхлээд далавчтай морь унасан Чингисийг дүрслэхээр төлөвлөсөн байна. Гэтэл Б.Ренчин, Х.Пэрлээ зэрэг зөвлөх эрдэмтэд зөвшөөрөөгүй ажээ. Тийм учраас өнөөгийн маягийн дээл өмсөөд зогсож буй Чингисийн хөргийг чулуун дээр сийлэхээр болсон байна.⁷¹ Уран барималч Чингисийг нисдэг хүлэг морь унуулснаар бурхан хэмээн үзэхийг оролдсон бол эрдэмтэд түүнийг нь хүлээн зөвшөөрөлгүй “хүн” гэдэг үүднээс дүрслэх нь зүйтэй гэж үзжээ.

Гэтэл “үндсэрхэг үзэлтэй” монголчуудын дээрх хөдөлгөөнийг ЗХУ анзааралгүй өнгөрүүлсэнгүй. Юуны түрүүнд “Правда” сонины 1962 оны 7 сарын 21-ний дугаарт, монголчуудын Чингис хааныг тахиx шүтэх үзлийг хурцаар шүүмжилсэн байна. Энэ далимд ерөнхий сайд, Намын төв нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал нь намын хоёр дахь лидер Д.Төмөр-Очир (Намын төв хорооны Улс төрийн товчооны нарийн бичгийн дарга)-ыг түлхэн унагаахдаа 800

⁶⁹ Мөн тэнд, тал 5.

⁷⁰ Ф-6, Д-1,хн-12, No.2.

⁷¹ Мөн тэнд, 28-р тал.

жилийн ойн баярын талаарх ЗХУ-ын шүүмжлэлийг ашиглав. Ойн арга хэмжээг хариуцаж байсан Д.Төмөр-Очирыг 9 сарын 10-нд баярыг хэт өргөн дэлгэр гүйцэтгэсэн “үндсэрхэх үзэлтэн”, улмаар “*Маршал Чойбалсангийн гавьяаг мартуулан баллаж, Чингис хааны үзүүлсэн амжилт хэмээн магтан дуулсан*” хэмээн хурцаар шүүмжилжээ.⁷² “*Чойбалсангийн гавьяаг Чингисийнх болгосон*” гэдэг нь гадаадын олон улстай дипломат харилцаа тогтоож, БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр элсүүлэх (1961 он) замыг нээсэн ерөнхий сайд Х.Чойбалсан агсан л тусгаар улсыг үүсгэн байгуулагч бөгөөд Чингисийг “*тусгаар улсыг үүсгэн байгуулагч*” гэж хэлж болохгүй хэмээжээ.

Мөн, тухайн жилийн 5 сард Хятадын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд ч Чингис хааны мэндэлсэн 800 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулагдав. Хятад Оросын харилцаа муудсан тухайн үед Д.Төмөр-Очирыг Хятадыг дэмжигч хэмээн шүүмжлэх болсон байна. Анхнаасаа Хятадад Чингисийг булаалгахгүйн тулд эхлүүлсэн ойн арга хэмжээ байсан бол, эсрэгээрээ буруу ойлголт төрүүлж орхив. Юутай ч Д.Төмөр-Очирыг улс төрийн хүрээнээс зайлуулж, сэхээтнүүдийг ч байцаан, хилсээр гүтгэн хэлмэгдүүлсэн байна.

1963 оны 1 сарын 9-нд Намын “Үнэн” сонинд Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Б.Ринчен нарын ШУА-ийн нөлөө бүхий эрдэмтдийг нэр заан шүүмжилж, үзэл суртлаар захирах тогтолцоо улам бүр гаарав.⁷³ Ялангуяа Ц.Дамдинсүрэнг тухайн жилийн 6 сард болсон Намын төв хорооны Улс төрийн товчооны III их хурлаар, Ю.Цэдэнбал “*800 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд үндсэрхэг үзэлтэй, арьс ясыг ялгаварласан тусгүй үг бичсэн*” хэмээн буруушааж,⁷⁴ ШУА-ийн Хэл утга зохиолын хүрээлэнгийн захиралын албанаас энгийн судлаач болгон тушаал бууруулав.⁷⁵ Мөн ойн баярын хүрээнд хийхээр төлөвлөсөн Чингисийн тухай киног зогсоон, түүний талаарх ном байтугай эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл өгүүллийг хүртэл хэвлэхийг хориглосон байна.⁷⁶

Энэ хэргээс хойш Чингисийн талаар ил тод ярих хориотой болж эхлэв. Үнэн хэрэгтээ 1966 оноос хойш “БНМАУ-ын түүх” номыг дахин эмхэтгэхээр болсон байна. Түүнчлэн 1984 онд хэвлэгдсэн гуравдах хэвлэл нь Чингисийн гавьяа зүтгэлийн хувьд, ЗХУ-ын эрдэмтдийн бүтээлийг орчуулан бичсэн анхны хэвлэл (1955 он)-ийн агуулгатай бараг ижил болсон ба нийт 667 хуудас номд Чингисийн гавьяа зүтгэлийн талаар 16 хуудас л бичжээ.⁷⁷

⁷² Цэдэнбал нь Чингисийн удмынхан түүний үр ачтай тэмцэлдсээр ирсэн ойрад угсааны дөрвөд хүн байсан.

⁷³ Окада Казүюки *Профессор Дамдинсүрэн агсаны гавьяа*, Тоокёогийн гадаад хэлний их сургуулийн эмхэтгэл, No.38. (1988), тал 276.

⁷⁴ Болдбаатар, *op.cit.*, тал 44.

⁷⁵ Окада Казүюки *Профессор Дамдинсүрэн агсаны гавьяа*, Тоокёогийн гадаад хэлний их сургуулийн эмхэтгэл, No.38. (1988), тал 277.

⁷⁶ Болдбаатар, *op.cit.*, тал 44.

⁷⁷ Ш.Бира, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, А.П. Окладников, С.Д.Дылыков, И.Ш.Казакевич (ред.), *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх нэмэж засварласан гурав дахь хэвлэл*, Улаанбаатар: Улсын Хэвлэлийн газар, 1984, тал 139-151.

Гэтэл энэхүү улс төрийн хэлмэгдүүлэлт төсөөлж байгаагүй сөрөг үр дагавартай байв. 5 сарын 31-нд Москвад суралцаж байсан залуу яруу найрагч Д.Пүрэвдорж (1933-2009)-ийн бичсэн “Чингис” шүлэг “Утга зохиол урлаг” сонинд нийтлэгдэж, тухайн үед радиогоор хүртэл уншиж байв. Тэгтэл энэ шүлэг нүд ирмэхийн зуур иргэдийн дунд ам дамжин дэлгэрсэн юм.

Дээрх шүлэг яг л хэн нэгний хэлснийг хүчтэй эсэргүүцэж байгаа гэмээр мөрөөр эхэлдэг. Улмаар зовлон бэрхийг даван туулж, Монголыг нэгтгэж байгаагаар үргэлжилдэг.

Тэмүжин - нумын хөвчнөөс төрөөгүй юм

Тэмүжин - сумын зэвнээс гараагүй юм

Тэмүжин - Өэлүн эхээс төрсөн юм

Тэмүжин - өрлөг түүхээс гарсан юм

Амар заяа хомс догolon нулимст хорвоод

Аврах тавилан мөхөс долоон үеийн тэртээд

Атаа хорслын манцуйд Есүхэйн хүү өсөж

Аян дайны онгодоор есөн тугаа тахисан юм

Товчлов

Тийм ээ, дайны мөрөөр цагаан сүү урсаагүй

Тийм ээ, дайчдын сүрийг цагийн саалт мартаагүй

Тийм ээ, Чингис өндөр Алтайд зартай юм

Тийм ээ, Чингис өнөөдөр ч гэсэн нэртэй юм

Хойч үедээ тэр хар буруу санаагүй

Хорин лангийн их гачаалд хатан Онон ширгээгүй

Чингисийн их Монгол ядарсан, гутарсан, задарсан

Чиний хөх Монгол ялсан, хөгжсөн, мандсан

Ямар ч байсан Чингис хаан-гарьд шиг хальж

Ял гавьяа хоёроо хойч үедээ даатгасан юм

Гал усанд элэгдсэн буурал замбуутивийн магнайд

Ган сэлмэнийхээ ирээр МОНГОЛ гэж бичсэн юм

Чингис - нумын хөвчнөөс төрөөгүй юм

Чингис - сумын зэвнээс гараагүй юм

Чингис - Өэлүн эхээс төрсөн юм

Чингис - өрлөг Монголоос гарсан юм⁷⁸

⁷⁸ Дэндэвийн Пүрэвдорж, Чингис, Л.Түдэв, П.Бадарч, Д.Нямаа, С.Эрдэнэ (ред.), *Монголын уран зохиолын дээж найман боть*: Би хаана төрөө вэ? “Монгол уран зохиол”, Улсын хэвлэлийн газар, 1994, тал 193-194.

Гэвч намын үзэл суртлын хэлтсээс энэ шүлгийг үндсэрхэг үзлийг илэрхийлсэн хэмээн шүүмжлэн хориглосноор, ардчилал ялах хүртэлх 28 жилийн хугацаанд дарагдсан юм.⁷⁹ Сүүлд нь зохиолч энэ шүлгээ “*сэтгэлийн нударга зангидаж шүтэн биширч бичсэн*” хэмээн дурссан бөгөөд, үнэхээр л тухайн цаг үеийг туулаагүй хүн бичиж чадахааргүй шүлэг байсан болов уу. Энэ шүлэг ардын аман зохиолын хэлбэрээр, толгой холбож бичсэн учраас цээжлэхэд тун хялбар. Тиймээс хүмүүсийн дунд ам дамжин нууцаар алдаршсан байна.

Тухайлбал, тухайн үед МУИС-ийн Утга зохиолын тэнхимд суралцаж байсан профессор Дагвадорж (1942 онд төрсөн, тухайн үед 20 настай)-ийн яриагаар энэ шүлгийг уншаад сэтгэл хөдөлсөн оюутнууд цээжээр уншицгаасан гэдэг. Ялангуяа утга зохиолын тэнхимийн арван хэдэн оюутан бүгд “Чингис” шүлгийг цээжилсэн бололтой.⁸⁰ Мөн тухайн үед Москвад суралцаж байсан профессор Г.Цэрэнханд (1938 онд төрсөн, тухайн үед 24 настай) ч ялгаагүй тэнд суралцаж байсан монгол оюутнуудын ихэнх нь мэргэжил үл хамааран энэ шүлгийг цээжээр уншдаг байсан талаар хүүрнэсэн билээ.⁸¹

Яагаад яруу найрагч яг л хэн нэгний үгийг эсэргүүцэх мэт “-аагүй”⁴ хэмээн давтах хэрэгтэй байсан юм бол. Тэмүүжин нумын хөвчнөөс төрсөн гэж хамгийн эхлээд нэг хүн хэлсэн байхаас зайлахгүй. Тэр бол ЗХУ-ын эрдэмтэд, зохиолчид гэвэл буруудах юмгүй. Учир нь Оросын баатарлаг туульд өөрсдийн дайсан болох аваар, половиц, монгол, казак зэрэг Азийн морьт үндэстнийг “*нум сумт овгийнхон*” хэмээн нэрлэдэг заншилтай байв.⁸²

Энэ хэргээс үүдэн тухайн үед 33 настай байсан зохиолч С.Эрдэнэ (1929-2000) “Чингис хаан”-ы талаар зохиол бичихсэн гэсэн хүсэлтэй болсон хэмээн ярьжээ. Ардчилал ялсны дараа тэрээр Чингисийн талаар “Мөнх тэнгэрийн хүчин дор” (1992 он, найруулагч Б.Балжинням) хэмээх уран сайхны кино зохиол бичжээ. Сүүлд нь С.Эрдэнэ энэ киноныхоо талаар “*Чингис хаан энгийн хүн байсныг хүмүүст харуулахаар зорьсон*” хэмээн хариулсан байдаг. Мөн тэрээр “*Өнөөг хүртэл гаднын улсад Чингис хааны талаар хэд хэдэн кино бүтээгээд байна. Гэтэл монголчууд бидний нүдээр энгийн хүн үүднээс нь авч үзсэн бүтээл огт байхгүй гэхэд хилсдэхгүй болов уу*”⁸³ гэжээ.

Юутай ч Чингисийн мэндэлсэн 800 жилийн ойн баярын үеэр зохион байгуулагдсан ЗХУ ба түүнийг дагалдагч удирдагч Ю.Цэдэнбал Чингис хааны талаарх дискурсыг дарснаараа эсрэгээрээ хүмүүс ялангуяа сэхээтнүүдийн ой ухаан дотор Чингисийг хурц тодоор үлдээх болсон юм.

⁷⁹ Д.Цэвээндорж, *Монголын уран зохиол дахь Чингис хааны дүрийн судалгаа*, Улаанбаатарын Их сургууль, 2007, тал 146-147.

⁸⁰ 2015 оны 8 сарын 12-нд зохиогчийн Улаанбаатарт хийсэн ярилцлага.

⁸¹ 2015 оны 8 сарын 25-нд зохиогчийн Улаанбаатарт хийсэн ярилцлага.

⁸² cf. Figes.op.cit., p.365.

⁸³ Мацүда Таданори, *Монгол сэргэж буй нүүдэлчин үндэстэн*, Шякай хёороншя: 1996, 20-122-р тал. (Matsuda Tadanori, *Mongoru-Yomigaeru yubokumin-*, Shakai hyoronsha, 1996, pp. 120-122.)

Төгсгөл – Социализмын/аар бүтээсэн үндэсний баатар

Энэхүү өгүүлэлдээ социализмын үед “БНМАУ-ын түүх” номын эмхэтгэл ба 1920-1960-аад оны Монгол дахь Чингис хааны дүр, тухайн төсөөллийг хэрхэн бүтээсэн процессыг судалснаар “хэвлэлийн социализм (printing socialism)”-аар үндсэрхэг үзэл бүрэлдэж буй үе шатыг тодруулсан билээ.

XX зууны эхэн үеэс Монголын сэхээтнүүд ЗХУ болон Европоос суралцсанаар урьд нь бурхан хэмээн шүтэгдэж ирсэн Чингисийг түүхэн, бодит хүн болгож домгийн хүрээнээс салган авч үзэх болов. Гэвч энэхүү туршилт нь 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлт, 1945 оны хуучин монгол бичгийг кирилл үсгээр сольсон зэрэг хэргээс болж мухардалд орж, сэхээтнүүдээс энгийн иргэдийн дунд дэлгэрч чадаагүй билээ. Харин энгийн иргэд 1951 онд 10.000 хувь хэвлэгдсэн В.Яны “Чингис хаан” роман, 1955 онд 25.000 хувь хэвлэгдсэн “БНМАУ-ын түүх” номын анхны хэвлэлээс хамгийн анх Чингисийн талаар ойлголт авч эхэлсэн юм. Эдгээр ном нь хэвшмэл үзэлтэй, тогтсон үгтэй, сөрөг агуулгатай байсан хэдий ч энгийн ард иргэд түүгээр дамжуулан, Чингис хаан Орос, Хятадыг эзэлсэн талаарх түүхийг аажим аажмаар мэдэж авцгаасан билээ.

Гэвч дэлхийн II дайны үед япончууд эзэн хаанаа амьд бурхан хэмээн үзсэн мэт Монголын сэхээтнүүд Чингис хааныг бурханчлан шүтэхийг хүсээгүй байжээ. Харин ч эсрэгээрээ 1966 оны “БНМАУ-ын түүх” хоёрдугаар хэвлэлд, европчуудын бүтээсэн Чингисийг “ад чөтгөр” болгон харуулсан “домгийн чанартай түүх”-ийг тухай үеийн Монголын эрдэмтэд түүхийн шинжлэх ухааны зүй ёсоор сурвалжаас эш татан шүүмжилсэн (зарим үед маш ухаалгаар Хятадаас түүхийн сурвалж олж авч байсан) бөгөөд мөн “Чингис” шүлгэнд түүний сайн муу талыг адил тэнцүү багтаан дүрслэх зэргээр “хүн” үүднээс авч үзсэн билээ. Үнэхээр л Чингисийн төрсөн газрыг тодорхойлсон, төрсөн өдрийг тогтооход ч их бага хэмжээгээр бурханчлан шүтэх гэмээр үйлдэл байсныг үгүйсгэх аргагүй. Гэхдээ тэдний дээрх үйлдэл нь Самаркандыг эзэлсэн гэмдэглэлийн өөрчлөлт, Ц.Дамдинсүрэнгийн шүүмжлэл, Д.Пүрэвдоржийн шүлгээс харахад ч бэлхнээ, заримдаа Монголын эрдэмтэд ЗХУ-ын эрдэмтдээс ч илүү позитивист бөгөөд мөн Монголын яруу найрагчид, уран зохиолчид нь ЗХУ-ын зохиолчдоос илүү социалист реализмд итгэж байсныг харуулж байв.

Эл өгүүллийн эхээр танилцуулсан Английн антропологич К. Каплонский социализмын үед зөвхөн Чингисийн тухай бичигдэж байсан эсэхийг шалгаж, тус үед Чингис хааны тухай өгүүлэхийг хориглож байгаагүй гэж үзсэн нь одоо ямар ч үндэслэлгүй “домгийн чанартай түүх (mythico-history with Western bias) байжээ гэж дүгнэхэд буруутахгүй буй за. Учир нь ЗХУ-ын ба Монголын эрдэмтэд ялгаагүй социализмын хүрээнээс Чингисийн талаар хэлэлцсэн билээ. Нэг үгээр

хэлбэл, социализм ба үндсэрхэг үзэл хоорондоо тэрсэлдсэн хэрэг биш. Чингис “феодал эзэн мөн, хүмүүсийг дарлан мөлжиж байсан, гадаад улсуудад гаслан зовлон учруулж байсан” зэрэг тэмдэглэлийг монголын “социалист” үзэлтэй эрдэмтэд мэдээж хүлээн зөвшөөрч байсан. Харин тэдний хүлээн зөвшөөрөөгүй зүйл бол, үзэл сурталтай огт хамааралгүйгээр ЗХУ-ын эрдэмтэд, зохиолчид Чингисийн хувь хүний зан чанарыг үгүйсгэн, яг л ад чөтгөр, эсвэл хуулиас гадуурх дээрэмчин мэтээр дүрсэлсэнд байгаа юм. Түүхийн ямар ч ул үндэслэл, нотолгоогүйгээр харгис хэрцгий, ноорхой хувцастай, үзэшгүй муухай царайтай, муу морь унасан зэргээр ад чөтгөрийн (demonization) дүрээр дүрсэлснийг, хүн төрөлд эргүүлэн хувиргах нь Монголын сэхээтнүүдийн хүсэл байсан нь зүй. Тэдний чин хатуу байр суурь бол Чингис бол хүний хүү болон мэндэлж, ядуу зүдүү амьдралаас өндийн, өөрийн хүчээр тусгаар Монгол улсыг байгуулсан хэмээх асуудал байв.

Ийнхүү социализмын үед тогтсон нотолгоот түүхээр монголын сэхээтнүүд Чингис хэмээх “хүний” дүрийг бүтээсэн гэж хэлж болно. Үүний зэрэгцээ орчин үежлийн явцад ЗХУ-ын сэхээтнүүд Хаант Оросын үеэс уламжлагдан ирсэн Чингисийн талаарх дискурс эсрэгээр (харилцан хэлэлцэж) бий болсон юм. Өөрөөр хэлбэл, ЗХУ домгийн дүр, мангас болгон бүтээсэн Чингисийн дүрийг Монголд социализмаар энэ хүрээнээс гаргаж, хүн болгон бүтээсэн билээ.

Ерөнхийдөө орчин үеийн төрт улсад үндсэрхэг үзэл бүрэлдэх явцад үндэсний баатраа бурханчлан шүтэх нь дэлхий даяаар нийтлэг үзэгдэл. Харин Монголд эсрэгээрээ Чингис гэдэг хүнийг домгийн хүрээнээс гаргаж, энгийн хүн болгон дүрсэлснээр үндсэрхэг үзэл бүрэлдсэн онцлогтой.

Гэтэл 1962 онд тохиосон Чингис хаан мэндэлсний 800 жилийн ойн баяраас үүдэн, маш өргөн хүрээг хамарсан сэхээтнүүдийн улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлж, Чингисийн талаар ярихыг хориглох болов. Харин энэ хориг нь эсрэгээр үйлчилж Монголын ард түмний дунд улам үндсэрхэг үзлийг бүтээх баялаг (cultural resource for nationalism) болсон ажээ. Өөрөөр хэлбэл Чингисийн нэрийг хорих тусмаа Чингис хааны үнэ цэнийг улам үнэтэй болгосон гэсэн үг. Кристиан Даниелсийн хэлснээр, мэдээллийг (нэрийг) нууцлах нь мэдлэгийг баялаг болгох чухал арга байдаг бөгөөд мөн нэгэнтээ соёлын баялаг болгосон мэдлэгийн ашгийг зөв хадгалах арга байдаг.⁸⁴

Мөн түүнээс гадна Монголчууд буруугаар ярьж, зөвөөр ойлгодог гэж ярьцгаадаг. Тэгэхээр нэгэн мэдээлэгчийн (informant) надад ярьсан “монголчууд Чингисийн талаарх сөрөг утгатай яриаг зөвөөр буюу өөрсдөдөө

⁸⁴ Кристиан Даниелс *Уламжлалт арга технологи баялаг болсон нь*, Учибори Мотомицу (ред.), *Баялаг ба хүн*, Баялгийн антропологи 1, Кообундоо, 2007, тал 82. (Christian Daniels, Shigen toshite no dentoo gijyutsu, Uchibori Motomitsu (ed), Shigen to ningen, shigen jinruigaku-1, koobundoo, 2007, pp.82)

ойлгомжтойгоор дахин тайлбарлаж ойлгосоор ирсэн”⁸⁵ нь дамжиггүй. Цаашлаад ад чөтгөр мэтээр дүрсэлсэн Чингисийн талаар ЗХУ-ын дүрийг “*Тэмүүжин-нумын хөвчнөөс төрөөгүй юм. Тэмүүжин-сумын зэвнээс гараагүй юм*” гэхчилэн “-аагүй” хэмээн давтаж хэлэн үгүйсгэсэн (зөвөөр ойлгосон) Д.Пүрэвдоржийн шүлэг ард иргэдийн дунд ам дамжин өргөнөөр дэлгэрсэн юм.

Ийнхүү эл өгүүлэлдээ А.Кампигийн социализмын үед Чингисийн тухай ярихыг хориглож байсан, социализмын дараа эрх чөлөөтэйгөөр ярьж эхэлсэн гэсэн хялбарчилсан онол бус, К.Каплонскийгийн дэвшүүлсэн Чингис хааны талаар ярихыг хориглож байсан зэрэг нь домог юм гэсэн барууны ялгаварладаг онол (western biased theory) биш, харин Чингисийн талаарх яриа *дарагдаж-хэлэлцээр хийж-реакци үзүүлсэн (нэрийг нууцалсан)* гэсэн үндсэрхэг үзэл бүрэлдэх дөрвөн процесстой болохыг тодруулсан билээ. Тодруулан хэлбэл, Монгол дахь Чингис хааны дүр нь, Чингисийг мангас болгон дүрсэлсэн ЗХУ-ын дарлагч дүр ба түүний эсрэг Монголын сэхээтнүүдийн хийсэн хэлэлцээр, цаашлаад энгийн иргэдийн яриаг урвуулан ойлгосны (мэдлэгийн ашгийг хадгалах) ачаар бий болсон юм.

Өнөө хэр нь сэхээтнүүд төдийгүй, монголчууд нийтгээрээ Чингисийг бурхны дүрээр биш, хүн хэмээн хүндлэх болсон юм. Үүний нотолгоо нь монголчууд социализм нурж, ардчилал ялсан ч Чингис хааныг бурхан хэмээн үзээгүй. Засгийн газрын ордон, Улаанбаатар хотын гадна аварга том Чингисийн хөшөө сүндэрлэсэн ч монголчууд түүнд сүслэн мөргөдөггүй. Тахилгын өвөрмөц зан үйл ч хийдэггүй.

Сонирхолтой нь өвөрмонголчууд Чингисийг тэднээс өөрөөр буюу үндэстний өвөг дээдэс-бурхан хэмээн шүтэн дээдэлдэг. Тэд Чингисийг бурхан хэмээн шүтэж, гэртээ ч тахилга үйлддэг. Мөн Чингисийн хөрөг зураггүй айл байхгүй гэмээр тэдний хувьд Чингис хаан бол сэтгэлийн түшиг нь байдаг ба Цагаан сараар заавал Чингисийн хөрөгний өмнө идээ ундаа тавьж мөргөдөг билээ.

Өвөр Монголын нийслэл Хөх хотод ажиллаж, амьдардаг эр (Монгол улсын иргэн) Чингист мөргөн залбирч байгаа өвөрмонголчуудыг хараад гайхсан талаараа надад ярьсан юм.⁸⁶ Мөн Монгол улсын Засгийн газрын ордны урд талд байдаг Чингис хааны хөшөөнд өвөрмонголчууд мөргөн залбирдаг гэж хотын хүмүүс ярьдаг. Үүнийг монголчууд хачирхан харцгаадаг аж. Харин ч монголчууд Чингисийн хөшөөний өмнө мөргөхийн оронд зүгээр зогсож зургаа авхуулдаг. Антропологич Урадын Булаг өнөөгийн монголчуудын үндсэрхэг үзэл зөвхөн ХХ зууны Монгол улс (хуучин Ар монголын нутаг)-д бүрэлдсэнээр өвөрмонголчуудыг өөрсөдтэй нь адил монгол хүн гэж үзэхээ больсон гэж онцолжээ.⁸⁷ Үнэндээ Чингисийг бурхан болгох, хүн болгох эсэх нь Ар ба

⁸⁵ 2015 оны 8 сарын 21-нд Улаанбаатарт зохиогчийн хийсэн судалгаа.

⁸⁶ 2015 оны 8 сарын 12-нд Хөх хотод зохиогчийн хийсэн судалгаа.

⁸⁷ Uradyn E.Bulag, *Nationalism and Hybridity in Mongolia*, Oxford: Clarendon Press, 1998.

Өвөрмонголын иргэдийн хооронд орших харь хүн (others) гэх хүрээг заасан ялгаа болж байгаа гэж хэлж болно.

Ар монголчууд Чингисийг шүтэхгүй болсон учир нь дундад зууны үеэс Чингисийн тахилгыг үйлдэж ирсэн дархад хэмээх хүмүүс Ордост байсан ба одоо ч байн тахилгыг үргэлжлүүлэн үйлдсээр байгаа бол дээрх уламжлал өнөөгийн Монгол улсад ХХ зуунаас аль эрт устан үгүй болсонтой холбоотой болов уу.

Хэдийгээр тийм боловч ЗХУ-ын хүлээснээс ангижирсан орчин үед ч Монголд Чингис хааныг тахидаг тахилч хүмүүс үгүй болсон учраас Чингисийг бурханчлан шүтдэггүй хэмээн тайлбарлаж болохгүй.⁸⁸ Учир нь “уламжлал” хэмээх зүйлийг зохиох боломжтойг дэлхийн олон соёлыг судалсан антропологичид нотолсон. Харин монголчуудын хувьд Чингисийн төрсөн өдрийг шинээр зохиож, түүнийгээ Монгол бахархлын өдөр⁸⁹ гэж нэрлэснээс өөр сүрхий зохиосон зүйл байдаггүй. Өөрөөр хэлбэл, хүн Чингис нь социализмын явцад монголчуудын дотоод сэтгэлд бий болсон үнэт зүйл, үнэлэмж юм.⁹⁰

ХХ зууныг хүртэл Чингисийн тахилгын баяр Ордосын нутагт болж байсан бөгөөд өнөөгийн Өвөрмонголын нутагт энэ зан үйлийг гүйцэтгэж байсан гэсэн үг биш. Японы антропологич Конагая Юки, өвөрмонголчуудын Чингисийн шүтлэгийг дэлхийн II дайны үед Японы квантуны армитай *хамтач үндсэрхэг үзэл (collaborative nationalism)*⁹¹ -ийн нөлөөгөөр бий болсон хэмээн үзжээ.⁹²

Харин өнөөгийн Монгол улсад зочид буудал, ресторан, шар айраг, архи гээд бүхий л зүйлийг Чингис хааны нэрээр замбараагүй нэрлэх болсон. Түүнчлэн, 1990-ээд онд ургийн овгоор нэрлэхээр тогтоосон хэдий ч, бараг ихэнх нь Чингисийн боржигон овгийг авцгаасан. Дээрх байдлыг антропологич, түүхч

⁸⁸ Үнэн хэрэгтээ 90-ээд оны эхээр Ордосын дархад тахилчийг урьж авчиран, Чингисийн онгон байгаа хэмээн үздэг Бурхан Халдун Хайрханы тахилгыг үйлдсэнээс хойш, бөө нар тахилга үйлдсэнээс бусдаар Монгол улсад Чингисийн тахилгын зан үйл үлдэж хоцроогүй.

⁸⁹ 2012 оноос аргын тооллын өвлийн эхэн сарын шинийн нэгэн (11 сар орчим)-д Чингис хааны төрсөн өдөр хэмээн тогтоож, “Монгол бахархлын өдөр” болгон тэмдэглэх болжээ. Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар 2012 оны 1 сарын 9-ний мэдэгдлээс харна уу.

<http://www.president.mn/content/2360>

⁹⁰ Чингис хааны талаар Монгол улс, Өвөрмонголд хэрхэн үздэг талаарх ялгааг Булаг 1998 онд бичсэн халх төвтэй үзэлтэй үндэстэн бүрэлдэх онол үнэн байсныг харуулж байна. Нөгөө талаар, Булаг 2010 онд бичсэн номондоо олон улс Чингисийг хэрхэн үзэж байсан талаар “Чингис нь Монгол улсаас илүү өргөн уудам” гэж хэлсэн ч энэ үг үнэн эсэх тухайд эргэлзээтэй байна. Булаг, *op.cit.*, Uradyn E.Bulag, *Collaborative Nationalism: The Politics of Friendship on China's Mongolian Frontier*, Lanham, Md.: Rowman and Littlefield Publishers, 2010.

⁹¹ “Хамтач үндсэрхэг үзэл”-ийн талаар Конагая ч дурьдсан хэдий ч Булагийн дэвшүүлсэн ойлголт юм. *Ibid.*

⁹² Конагая Юки *Чингис хааны тахилгын орчин үеийн үүсэл-Япон Монголын хариултаас*, Улсын төв Угсаатан судлалын музейн судалгааны тайлан-37 боть, No.4 (2013), тал 425-447. Мөн доорх онолын номноос дэлгэрэнгүй харах боломжтой. Широкава Сахо, Чингис хааны тахилга ба Орчин үеийн Өвөр Монгол, Шираиши Норуюки (ред.) *Чингискан ба түүний он цаг*, Бэнсэй шюппан, 2015, тал 339-355.

(Konagaya Yuki, Chingisu haan suuhai no kindaiteki kigen-nihon to mongoru no ooto kankei kara-, Kokuritsu minzoku hakubutsukan kenkyu hookoku, 37-4 (2013), pp.425-447.)

Л.Мөнх-Эрдэнэ “сайн эцгийн нэрийг гурав худалдах” хэмээх хэлц үгийг эш татан, Чингисийг хэт их магтан дуулж байна хэмээн шүүмжлэн бичжээ.⁹³

Гэхдээ Чингисийг бурхан, эсвэл мангас болгон ашиглахаар санаархсан колоничлогч нарын аргатай харьцуулахад, монголчуудын дүрсэлсэн Чингис хэмээх хүний дүр илүү бодитой гэмээр. Тэр бол социализмын үед монголчууд ЗХУ-тай харилцан хэлэлцэж байж, бурхан хэмээх хүрэнээс салган, олж авсан хүний дүр байсан нь дамжиггүй. Тийм учраас Чингис хаан бол социализмын/аар бүтээсэн үндэсний баатар билээ.

⁹³ L.Monkh-Erdene, “Selling of Good Father s Name Legitimacy”, Pride, and Commodity, Хүмүүн соёл, Шига мужийн хүмүүн соёлын факультетийн судалгааны тайлан, No.24, 2008. тал 35-46.